

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-31

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 6-31

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
12 дугаар сарын 06-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Чойжилсүрэн.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, ахлах шинжээч Э.Төрбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, Ж.Батжаргал, Г.Дамдинням, Т.Аубакир, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Д.Батбаяр, Г.Дамдинням, Г.Ганбаатар, П.Мөнхтулга нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: 1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж,

чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 4
Бүгд: 23
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 4
Бүгд: 23
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23

78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 4

Бүгд: 23

82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 3

Бүгд: 23

87.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 5

Бүгд: 23

78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 5

Бүгд: 23

78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 92.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
9 цаг 20 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд ирэх ёстой 25 гишүүнээс 13 гишүүн ирж, ирц 56 хувьтай байгаа учраас хуралдаанаа эхэлье. Өнөөдрийн хуралдаанд Ринчиндоржийн Батболд, Батмөнхийн Батцэцэг, Хассуурийн Ганхуяг, Баатаржавын Мөнхсоёл, Банзрагчийн Түвшин, Жигжидийн Батжаргал, Хөххүүгийн Болормаа, Цэрэнпилийн Даваасүрэн, Пүрэвбаатарын Мөнхтулга, Даваагийн Цогтбаатар, Дамбын Батлут, Жамбалын Ганбаатар, Гонгорын Дамдинням, Даваахүүгийн Пүрэвдаваа нар оролцож байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, хуралдааны ирц 56 хувьтай байгаа учраас 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааныг эхэлье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдолтойгоор саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн нийт 11 хууль, 4 тогтоолын төслүүд буюу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын хуулийн зарим хэсэг заалт хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Баярсайханы Солонгоо ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны

Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны хөрөнгө оруулалт, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн хүмүүс оролцож байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн танилцуулгыг Батцэцэг сайд танилцуулна. Батцэцэг сайд танилцуулж байна.

Б.Батцэцэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч дурдвал 1.Хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төсөв хооронд үе шаттай оновчтой зохицуулалт хийх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, 2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олон нийтийн болон хараат бус хөндлөнгийн хяналтыг өргөжүүлж, сахилга бат, хариуцлагыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 3.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулах үйлдвэрүүдийг татварын бодлогоор дэмжих зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх төслийг дэмжих зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 4.Төсвийн урсгал зардал бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 5.Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжааны оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, жишиг хүүг тогтоох, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 6.Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, байгаль, цаг уурын болон бусад болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсрууллаа.

Хууль тогтоомжийн төслүүд батлагдсанаар бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж, бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бие даан хөрөнгө оруулалт

татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх, урсгал зардлыг бууруулах боломжийг бүрдүүлнэ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батцэцэг сайдад баярлалаа. Энэ Төсвийн хуулиа авч гарах чинь тэгээд ЗГ-ын гол ажил шүү дээ. Тэгээд сайд өөрөө ирж асуултад хариулахгүй бол болохгүй шүү. Сайдыгаа дуудъя. Эдийн засаг ч энэ дээр нэг их хамаагүй төсвийн хүрээ биш юм чинь. Сангийн сайд зайлшгүй байх хэрэгтэй шүү. Дуудъя. Энэ чинь та нарын гол ажил шүү дээ. Асуулт асуух гишүүдийнхээ нэрсийг авъя. Ганхуяг гишүүнээр тасаллаа. Сайдыг дуудъя. Энхбаяр гишүүний нэр орохгүй байна гээд байх юм. Энхбаяр гишүүний нэрийг оруулчих үг хэлэх дээр, асуулт, асуулт дээр шүү. Хариулах дээр уг нь Сангийн сайд өөрөө байж байж. Энэ чинь нөгөө төсөв дагасан хуулиуд байгаа байхгүй юу. Яах вэ ер нь энэ төсөв дагасан хуулиудыг холбогдох Байнгын хороод бас хэлэлцэхээр байгаа. Соёлын хуулийг жишээлбэл соёлын асуудал эрхэлсэн Байнгын хороонууд нь хэлэлцээд явахаар юм байгаа. Ирж байна уу? Ганбаатар гишүүн асууя тэгвэл. Сайдаас асуух гишүүд хүлээе. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Ганхуяг гишүүнд бас баярлалаа. Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль гээд бид 22 онд баталсан. Би ажлын хэсэгт нь орж ажилласан. Тэр 4 номер, 5 номерт, 6 номерт байгаа дарга нар сайн мэдэж байгаа. Тухайн үед зөндөө л зүйл ярьсан, тэгээд л их загнуулсан ч гэж дээ их л хялалзуулсан даа намайг. Энэ жил гоё болчихно, дараа жил гоё болчихно, та буруу ярьж байна гээд л байсан. Одоо тэгээд энэ Төр, хувийн хэвшлийн тухай хуулиар өчигдрийн хариултуудыг сонсоход бол ер нь бол Эдийн засгийн сайд бол дандаа л Төр, хувийн хэвшлийн хуулийг ярьж байна лээ. Ер нь бол яах вэ эдийн засаг суурьтай гишүүдийн асууж байгаа асуултад хариулж байгаа хариултын бараг 80 хувь нь Төр, хувийн хэвшлийн хуулийг ярьж байна лээ. Тэгээд энэ хуулиар 22 оноос хойш юу хэрэгжив, ямар төсөл, юу бүтээн байгуулав Ганбат дарга аа? Ямар ажил, үйлчилгээ явав? Энэ хуульд одоо дагаж мөрдөхдөө өөрчлөлт оруулж байгаа юу?

Миний ойлгож байгаагаар энэ хууль чинь бүтэхгүй байна. Хувийн хэвшил хүлээж авахгүй байна, 3 жил боллоо. Гадаадын хөрөнгө оруулагч нар ирэхгүй байна. Та тэгээд энэ хуульд өөрчлөлт оруулсан зүйл байна уу, үгүй юу? Юуг сайжруулж байна вэ? 1 хуудас зүйл харагдсан учраас би асууж байна. Тэгээд түүн дотор энэ уншихаар бол өөрчлөлт орсон зүйл бол байхгүй байна. Нэг тийм нэг бэлгэдлийн чанартай нэг хэдэн үг биччихсэн юм уу гэж харсан. Би буруу харчихсан юм уу, зөв харчихсан юм уу хариулаарай. Би өмнөх төсөв өргөн барихад нь тэр Амнатын, Амнат чинь бол уг нь бол зарцуулах ёстой хөрөнгө, юу татвар биш шүү дээ, хадгалах ёстой бүгд мэдэж байгаа. Тэгээд тэрийг ингээд 65 хувийг Ирээдүйн өв санд хадгална гээд Ганбат дарга сайн мэдэж байгаа. Тэгээд бүгдээрээ ярьсаар байгаад саяхан энэ 4 сард билүү, 3 сард хийсэн шүү дээ. Тэгээд яагаад буцаагаад 40 болгочихсон юм бэ? Би дандаа дагасан хуулиас асууж байгаа шүү. Үгүй ээ энэ чинь тэгээд одоо 82 сая тонн нүүрс зарна. Манай гишүүд ингээд төсөв алдагдалгүй гоё боллоо л гээд байгаа.

Уул уурхайн яам бол 60 сая тонн нүүрс 25 онд зарах чадвартай гэсэн ийм тоог бол Сангийн яам, Эдийн засгийн яаманд хүргүүлсэн шүү. Уул уурхайн яам гэхээр би биш. Энэ чинь олон хүчин зүйл, олон зүйлүүдийг харгалзаад, ер нь бол 25 онд ер нь 60 л хүрэх юм байна гэж тооцсон гэсэн үг. Тэгээд өнөөдөр бол 82. Тэгээд алдагдалгүй төсөв. Цаана нь юу сонсогдож байгааг ойлгож байгаа байх. Өнөөдөр 74, 5 байж болно л доо. Өнөөдөр 74, 5 гэдэг чинь дараа жил 80, 85 гэсэн үг биш шүү дээ. Ингэж тооцно гэвэл уучлаарай өнхрөөд унана шүү дээ. Тэгээд ингэж тооцдог хүн гэж байдаг юм уу? Тэр чинь жил болгон олон хүчин зүйл өөрчлөгдөнө. Тэр жилтэйгээ л холбож олон хүчин зүйлтэй холбож л тоог тавихаас биш өнөөдөр ийм байна, маргааш тийм болно гэж ингэж бодно гэж их хөнгөхөн хөнгөн бодож байна гэсэн үг шүү дээ. Өнөөдөр 74 гаргаж байгаа, маргааш 80 гаргана гэдэг чинь их л тийм. Тэгээд мэргэжлийн яам нь 60 гээд өгчхөөд байхад хэн тэрийг нь өөрчилдөг юм бэ Ганбат? Асуулт дууслаа.

Ц.Даваасүрэн: Сайдыгаа дуудна шүү. Ганбат хариулж байя. Тэгээд хэдүүлээ энэ Төсвийн хуулийг цаг хугацаа, цаглаврын дагуу нь батлахын тулд өөрсдөө ЗГ-ын гишүүд нь идэвхтэй байх хэрэгтэй шүү дээ, ялангуяа Сангийн сайд. Тийм учраас энэ асуулт асуугаад байгаа гишүүдийг хүлээлгэлгүйгээр яаралтай ирэх хэрэгтэй байна. Ганбат гишүүн хариулъя, Ганбат ТНБД хариулъя, 5 номерын микрофон.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Ирээдүй өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс хуваарилах саналыг бол бид 2025 онд 40 хувь байхаар бол ингэж тооцсон байгаа. 2024 оны төсөвтэй хамт оруулж ирсэн дээр бол Улсын Их Хурал дээр санал гаргаад 40 байсныг бол 65 хувь болгосон байгаа. Гэхдээ энэ дээр бол бид нөгөө төсвийнхөө боломж, мөнгөн хөрөнгийнхөө байдалтай уялдуулаад энэ асуудлыг зохицуулах байдлаар авч үзээд ингэж байгаа. Тэгээд хууль дээрээ бол бид 65 хувьд үе шаттай хүрнэ гэж ингэж тооцоод, 26 онд бид 65 хувьдаа хүрье, тэгээд Үндэсний баялгийн санг дагаж мөрдөх журмын тухай хуульд бол 2024 онд 20 хувь, тэгээд 2025 онд 40 хувь, 26 онд 60 хувь, 65 хувьд хүрнэ гэж ингэж бол тооцсон байгаа. Энэ дээр бол ингэсэн.

Хоёр дахь нь яах вэ би таны тэр нүүрстэй холбоотой асуудлыг Сангийн яам бол төсөв боловсруулахдаа өмнөх жилүүдийн гүйцэтгэл, тэгээд яг тухайн жилийнхээ эхний хагас жилийн гүйцэтгэл, тэгээд дараа жилүүдийн төсөөлөл дээрээ үндэслэж төсвийг боловсруулдаг. Тэгээд яах вэ мэдээж салбарын яамнаас саналыг нь авдаг. Тэгээд гол экспортолдог компаниудаас бол бид бас дараа жилийнх нь төсөөллүүдийг нь бол авдаг. Энэ бүгд дээрээ үндэслээд бол бид юун дээрээ орлого талдаа бол экспортынхоо бүтээгдэхүүнийг бол хэмжээг нь бол ингэж тооцдог байгаа. Өнөөдрийн байдлаар бол нүүрс 79 орчим сая тонн нүүрс өнөөдрийн байдлаар Монгол Улс бол экспортолчихоод байгаа гэдэг ийм юм байгаа. Бид бол аль болох Сангийн яам эрсдэлийг тооцож ингэж үздэг байгаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бол бид энэ асуудал дээр олон улсын байгууллагууд, НҮБ-ын жишгийн дагуу энэ хуулийг бол боловсруулаад, хэрэгжих ингээд боловсруулсан байгаа. Боловсруулаад, батлуулаад. Энэ Концессын хуулийн хэрэгжилтэд бол хамгийн гол асуудал бол яг ний нуугүй хэлэхэд манай дээр төслүүд бэлэн биш байгаа. Төслүүдийн ТЭЗҮ, төслүүдэд үнэлгээ өгөх, судалгаа хийх энэ асуудлууд бэлэн биш учраас энэ хуулийг хэрэгжүүлэхэд хугацаа хойшлоод байгаа ийм асуудлууд байгаа.

Ер нь бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бол чиг үүргийнхээ дагуу бол Эдийн засгийн хөгжлийн яам хариуцаж байгаа. 24 оны 6 сард баталсан Хот, тосгоны хуулиар бол нийслэл дангаараа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг хэрэгжүүлэх бол эрхээ авсан байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол Нийслэл өөрсдөө энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлж эхлэхээр ажлууд зохион байгуулагдаж байгаа, зохион байгуулаад явж байгаа гэж ингэж бол ойлгож байгаа. Юун дээр Эдийн засгийн хөгжлийн яаман дээр энэ асуудлыг хуулийн өөрчлөлтийг бол судлаад, энэ асуудлаар танилцуулахаар ажиллаж байгаа юм байна лээ.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн тодруулъя. Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Ерөнхий сайд хувийн хэвшлийнхэнтэй 3 ч уулзалт хийсэн. Ганбат дарга өөрөө байсан байх бараг. Тэгээд гурвуулан дээр нь дандаа өөр салбарын хүмүүс ирсэн, бүгд шүүмжилсэн, засна гэсэн. Тэгээд энэ ташрамд засаж яагаад болохгүй байгаа юм бэ л гэж хэлж байгаа юм. Тэгээд наад явах гэж байгаа өнөөдөр бараг мянгаад төсөл байгаа. Үгүй ээ тэгээд 1 нь ч явахгүй байхад энэ чинь хуулиа засахгүй нэг журам хийнэ гэсэн нэг өгүүлбэр наад дагаж байгаа хууль дээр чинь харагдана лээ ЗГ-ын журам. Үгүй ээ тэгээд Энхбаяр гишүүнээс эхлүүлээд энэ журам гэдэг зүйл ер нь болохгүй гээд байгаа шүү дээ. Хууль байх ёстой. Тэгээд энэ чинь өөрөө аягүй учир дутагдалтай. 1-хэн минут учраас, тэр өчигдөр бас зарим гишүүд хэлж байна лээ. Энэ 79 сая тонн нүүрс зарлаа, мөнгө нь хаана байна вэ? Өмнөх жил 60 сая тонн нүүрс зарсан бил үү, тэгээд 6 тэрбум доллартой байсан. Одоо ингээд 4 тэрбум доллар. Сая нэг бонд зараад 500 сая.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минут нэмээд өгье Ганбаатар дарга, Ганбаатарт 1 минут өгье.

Ж.Ганбаатар: Ер нь тэгээд энэ хар даа та нар энэ, тэр нэг танай тэр юу чинь таны оронд очсон тэр нэг дарга чинь сониноор юм бичээд л Эрдэнэс Тавантолгойн захирал. Өөрийгөө их мундаг гээд юм бичээд байна лээ. Би тэр тоог нь дахиад нэг сануулаад хэлье. 7 сарын 1-ний дотор, өмнөх сонгуулийн өмнөх ЗГ гэсэн үг шүү дээ Эрдэнэс Тавантолгой 14 сая тонн нүүрс экспортлоод, 10 саяыг нь биржээр зарсан. Маш их мөнгө Монголбанканд хуримтлагдсан гэсэн үг. Өнөөдөр 7 сарын 1-нээс хойш ахиад 14 сая тонн нүүрс экспортолсон. 4-хөн саяыг нь зарсан. Хэд дахин унасан байна вэ, 60, 70 хувь унасан байна шүү дээ. Тэр их нүүрс зараад Монголбанканд мөнгө байхгүй, Монголын валютын нөөц нэмэгдэхгүй юм бол зарж яах гээд байгаа юм бэ? Тэгээд энэ чинь өөрөө маш том асуулт шүү дээ. Маш том асуулт. Тэгээд л бүтэн жилийн дүнгээрээ өсөж.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн хариулт авах юм уу, санал юм уу? Хариулъя, Ганбат 5 номерын микрофон хариулъя. Төр, хувийн хэвшилтэй холбогдолтой дутуу хариуллаа гэж байгаа юм байна.

Ж.Ганбат: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бол ЗГ-ын түвшинд бол энийг хялбаршуулна гэдэг асуудлыг арай ийм байдлаар бол ажиллаж байгаа Эдийн засгийн хөгжлийн яам дээр хялбаршуулах. Энэ хууль дээр тэр янз бүрийн босгууд дээр энэ тэр бол заримыг нь арай хялбаршуулсан байдлаар шилжүүлэхээр Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ажиллаж байгаа. Энэ Улсын

Их Хурлаар батлагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг хэрэгжүүлэхэд боол нэг хүндрэлтэй байгаа асуудлууд байгаа. Миний түрүүнд хэлсэн нийслэл Улаанбаатар хотод өөрсдөө хэрэгжүүлэх эрхийг нь өгчихсөн учраас нийслэл өөрсдөө төслүүдийнхээ бэлэн байдлыг нь хангаад хэрэгжүүлнэ. Тэгээд яах вэ Эдийн засгийн хөгжлийн яаман дээр энэ хуулийг хялбаршуулах талд нь бол ажлын хэсэг гараад ажиллаад энийг бол ойрын үед саналаа ЗГ танилцуулаад, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулна гэдэг ийм байдлаар бол Эдийн засгийн хөгжлийн сайд бол ярьсан ийм байгаа. Бид юун дээр тэр таны саяын хэлээд байгаа яах вэ бид 79 сая тонн нүүрсний экспортын орлого бол Монгол Улсад орж ирсэн.

Ц.Даваасүрэн: Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Хэд хэдэн асуудал байна. Бид нар яг төсвөө харахаар эдийн засаг талдаа тогтолцооны өөрчлөлт хийх, нөгөө хууль, эрх зүйн юундаа тохируулах гэсэн асуудлууд жоохон бага л харагдаад байгаа юм л даа. Сая энэ Ганбаатар гишүүн ч хэлж байна, Энхбаяр гишүүн ч яриад байгаа юм. 26 сан ЗГ-ын тусгай сан байгаа. Тэгээд бид нар энэ төсөв дээр бол энэ сангуудтай холбоотой мэдээлэл бол байхгүй байна. Зөвхөн Нийгмийн даатгал, ЭМД гээд 2 сангийн асуудал харагдаж байна.

Тэгээд энэ 8 сан нь л хуулиар зохицуулагдаад байгаа байхгүй юу. Одоо энэ 2 сан татан буулгаж байгаа нь сайн байна. Энэ чинь бүүр зүгээр зээл биш, зүгээр шууд санхүүжилт өгдөг байсан 2 сан байхгүй юу буцалтгүй. Тэгээд 1 төсөл хийгээд, 1 киноны төсөл хийгээд тэгээд ерөөсөө 3, 4 сангаас ингээд авчихдаг ийм тохиолдол хүртэл байсан шүү. Би өөрөө энэ сангуудыг шалгасан болохоор мэдээд байгаа юм. Энэ сангуудынхаа учрыг хэзээ олох юм бэ? 17 сан нь, одоо 2 нь хасагдаад, 15 сан нь журмаар зохицуулаад байгаа байхгүй юу. Нэг ёсондоо сайд өөрөө журмаа хийчхээд, тэгээд сонгон шалгаруулалт хийгээд байгаа юм. Тэгээд энэнийхээ учрыг нэг тийш нь болгомоор байна.

Өнгөрсөн парламентын үед бид нар Баялгийн сангийн хуулийг нэлээн аятайхан болгосон. Тэгээд энэ Хуримтлалын сангаар ипотекийн зээлийн эх үүсвэрийг олгох юм шиг байна лээ. Тэнд нэг сайд карманаасаа бэлэг өгөх гэж байгаа юм шиг юм яриад л 50 хувийг нь тэндээс төлнө гээд л юм яриад байгаа харагдана лээ. Би нэр ус хэлээд яах вэ. Өнөөдөр ипотекийн зээл чинь олдохгүй байна шүү дээ, 2 жилийн хугацаатай очертой байна, 2 жилийн хугацаатай. Энэ чинь яаж олон хүнд хүрэхээ бодохгүй, нөгөө авах гэж байгаа байрных нь 50 хувийг нь урьдчилгаа дээр нь яана л гэнэ, 6 хувийг нь 3 хувь болгоно л гэнэ гэнэ. Энэ нэг ийм карманаасаа өөрийнхөө мөнгөөр бэлэг авч өгч байгаа бол хамаа алга. Тэгээд энэ асуудлуудаа ер нь хэзээ танилцуулах юм бэ? Хуримтлалын сангийн журмыг та нар Их Хуралд танилцуулах ёстой байгаа шүү дээ. Энэ журмаа хэзээ танилцуулах юм бэ 1 дүгээр, 2 дугаар асуудал?

3 дугаар асуудал бол энэ Дэлхийн банкны судалгаа гээд жил болгон хийдэг. Тэгээд манай энэ төрийнхөн маань тэр судалгаа эд нар ер нь уншдаг уу, хардаг уу? Энэ ЖДҮ-ийн сан байна, Инновацын сан байна, Батлан даалтын сан байна. Дандаа нөгөө уламжлалт бизнес буюу тэр нөгөө мал аж ахуй эд нартаа олгоод байдаг, тэгээд ямар ч эдийн засгийн үр өгөөж алга байна гэсэн ийм асуудал яригдаж байна лээ шүү дээ. Ядаж тэр хөдөө аж ахуйн салбарт нь өгч байгаа бол тэр эрчимжсэн мал аж ахуйд нь өгдөг байх. Нөгөө мэдээлэл технологийн start-up, IT энэ чиглэл рүүгээ өгдөг болчихвол эргээгээд тэрний эдийн засагт үзүүлэх үр

өгөөж нь сайн байх юм гэдэг ийм дүгнэлт бол байж байна лээ шүү дээ. Та бүхэн тэрийг танилцсан байлгүй дээ бодвол. Энэ дээр нэг мэдээлэл авчихмаар байна. Эргээд дахиад тодруулъя даргаа.

Ц.Даваасүрэн: Хариулж байя, сайд ирж байх шиг байна. 5 номерын микрофон.

Ж.Ганбат: Бид төсөв дээр бол энэ нөгөө Засгийн газрын өргөн барьсан төсвийн 32 дугаар хуудас дээр бол бид ЗГ-ын тусгай сангуудын талаар бол бид нар танилцуулга дээр бол оруулсан байгаа. Хуримтлалын сангийн журмыг Нийгмийн хамгааллын яам хуримтлалын сангийн чиг үүргээр хариуцаж байгаа учраас Нийгмийн хамгааллын яам энэ талын журам дээр энэ тэр бол ажиллаад ингээд явж байгаа гэж бид ойлгож байгаа. Одоо яг нийтдээ энэ дээр яг засгийн, юунаас улсын төсвөөс санхүүжилт авч байгаа 22 сан байгаа. Тэгээд хуульгүй сан гэж бол байхгүй байгаа. Зөвхөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан сангуудыг бол бид бол байгуулсан ийм байгаа. Өмнө нь бол яах вэ 17, 18, 19 онуудад бол ЗГ-ын тусгай сангуудын талаар бол Сангийн яамнаас бол иж бүрэн шалгалтууд хийж, энэ сангуудыг цэгцлэх, цөөлөөд татан буулгах ажлуудыг бол нэлээн эрчтэй хийгээд, энэ сангууд бол 22 сан болоод ингэчихсэн. Нэмээд бол 2 санг татан буулгах бол ийм юм байгаа.

Тэгээд яах вэ сангууд дээр бол Сангийн яам болон Засгийн газраас барьж байгаа гол баримталж байгаа зарчим бол бид бол сангуудыг байгуулахыг аль болох дэмждэггүй юм. Сан байгуулна гэдэг нь эргээд төсвийн сахилга батыг зөрчих, зориулалт бус зардал гаргах энэ тэр гээд дандаа сөрөг үр дүнгүүд. Ер нь сангууд дээр бол байгуулаад үр дүнд хүрсэн юмнууд маш ховор байдаг. Тэгээд ийм учраас Сангийн яам болон Засгийн газраас аль болох сангуудыг байгуулахгүй, холбогдох зардлуудыг нь бол сан байгуулахгүйгээр төсвийн орлого, зарлага талдаа тэр сангийн эрхэлж байгаа үйл ажиллагаанд тусгаад явах бүрэн бололцоотой юм гэдэг ийм байр суурийг баримталж байгаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1-д заасан тусгай сангийн төсөв нь бол ингээд улсын төсвийн хөрөнгө, хандив тусламж, тусгай сангийн үйл ажиллагааны орлого, зээлийн хүүгийн орлогын эх үүсвэрээр бүрдэхээр бол заасан байдаг. Тэгээд энэ хүрээнд 2024 онд ЗГ-ын тусгай сангуудаар дамжин нийт 11 их наяд 582,6 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлэх, тэгээд үүний 92,4 хувь буюу 10,7 их наяд төгрөг нь бол нийгмийн даатгал, нийгмийн халамж, ЭМД-ын сангууд байгаа. Энэ дээр гол сангууд дээр саяын хэлдэг сангууд бол дийлэнх гол асуудлуудыг нь эрхэлж байгаа. Тэгээд бусад сангууд дээр бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан, Авто замын сан гээд, ЗГ-ын нөөц сан, Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сан гээд энэ сангуудыг аль болох цэгцлээд, бид нар төсөв дээр бол энэ сангуудыг нь бол нэгтгэх, бүрэн хяналтдаа авах ийм байдлаар бол ажиллаж байгаа. Тэгээд Соёл, урлагийн бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих санг бол бид татан буулгахаар хуулийн төслийг оруулж ирсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Энэ төсөв дээр гадаадын зээл, тусламж ашиглахтай холбоотойгоор дүнг бууруулсан байна лээ. Тэгээд яг бид нар өчигдөр Мянганы сорилтын сангийнхантай уулзсан. Тэгээд өчигдөр манай бас нэг биш гишүүд энэ

Мөнхсоёл гишүүн, Аубакир гишүүн энэ тэр асуугаад байна лээ. Тэр цэвэрлэх байгууламжийг ирэх жил дуусгаж байж энэ Мянганы сорилтын сангийн төсөл амжилттай хэрэгжих нөхцөл бүрдэх юм байна лээ. Тэр цэвэрлэх байгууламжаас гарч байгаа цэвэршүүлсэн, цэвэрлэгдсэн дахин боловсруулагдсан ус нь стандартын шаардлага хангаж байж Мянганы сорилтын сангийн төсөл амжилттай болох юм байна лээ шүү. Тэгээд энэ дээр би та нараас хариулт авах гээд байгаа юм. Энэ тэр зээлийн гадаад зээл, тусламжийн тэр хасалт хийгээд байгаа чинь энэтэй холбоотой юу, холбоогүй юу 1 дүгээр асуудал?

2 дугаар Сангийн яам тэр яг Мянганы сорилтын сангийн энд байгаа төслийн нэгжийг удирдаж байгаа юм байна лээ, улсын үйлдвэрийн газар гэдэг нэртэйгээр. Тэгэхээр энэ дээр ирэх жил тэр цэвэрлэх байгууламж дуусах уу? Мянганы сорилтын сан.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Дагаж байгаа хууль хэлэлцэж байгаа шүү дээ. Дэг л зөрчигдөөд байгаа юм л даа уг нь. Юу ч гэсэн тэр МСС-тай холбогдолтой нөгөө тэр саарал усны стандарт хангагдах асуудал, тэгээд энэ ирэх жилд чинь МСС хэрвээ бид нар хугацаандаа үүргээ биелүүлээгүй байвал тэгээд л хаагдчих юм байна лээ шүү дээ. Тэр мөнгийг нь татаж авах ямар ч бололцоогүй болох юм байна лээ. Энэ дээр хариулчихъя, микрофоныг өгчихье.

Ж.Ганбат: Бид бол тусламжийн эх үүсвэрийг бууруулаагүй. Мянганы сорилтын сан бол тусламж байгаа юм. Тэгэхээр энэ бол бүрэн хэрэгжээд байгаа. Тэгээд Мянганы сорилтын санг бол Сангийн яам бол Удирдах зөвлөлийг нь ахалж ингэж бол ажилладаг. Тэгэхээр энэ төсөл бол ирэх жил дуусна. Бид саяхан Мянганы сорилтын сангийн энэ удирдлагуудтай уулзаж, энэ талаар санал солилцоод, энэ дээр бол нэлээн ач холбогдол өгөөд, дуусах үед.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Трансформаторын дэд станц барих, дулааны шугам татах энэ тэр нь дулааны шугам нь лав очоогүй л байна лээ.

Ж.Ганбат: Юмнууд нь бол хийгдээд явж байгаа. Тэгээд цэвэрлэх байгууламж бол гэрээгээрээ 8 дугаар сард бол усаа нийлүүлэхээр бол ажиллаж байгаа. Төв цэвэрлэх байгууламж бол БНХАУ-ын зээлээр хэрэгжиж байгаа. Бид бол тэр зээл, тусламжийн хөрөнгө бууруулсан дээр бол зөвхөн хиймэл дагуул болон.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Дутуу хариулсан бол 1 минут Ганхуяг гишүүн.

Ж.Ганхуяг: Саяын асуултыг гүйцээгээд хариулчхаарай. Тэгээд энэ төсөв дагаад энэ Төрийн өмчит компанийн хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирсэн байна лээ. Тэгээд тэрийг алдагдалтай ажиллавал 3 жилийн дараа татан буулгана гэсэн асуудал байгаа. Тэгэхээр нөгөө Төрийн өмчит компанийн хуулийг оруулж ирэхгүй бол энэ чинь ингээд сэглээд, сэглээд хаях гээд байна л даа. Одоо би бол Энхбаяр гишүүнийг бас хэлэх болов уу гэж бодож байгаа. Алдагдалтай ажилладаг зарим компаниуд бий. Тэгэхдээ энэ чинь бас нөгөө нийтийн үйлчилгээ үзүүлж байгаа компаниуд угаасаа л алдагдалтай ажиллана. Тэр чинь угаасаа татаасаар явдаг үйлчилгээнүүд байдаг байхгүй юу. Хог, цэвэр ус. Тэр гэр хороолол руу ус зөөж байгаа компани яаж ашигтай ажиллах юм бэ? Ашигтай ажиллуулна гэх юм бол тэр усных нь үнэ дийлдэхээ болино шүү дээ. Тэгээд энэ нэг энэ Төрийн өмчит

компанийн хуулиа зүгээр бүтнээр нь шинэчилсэн найруулгаа оруулж ир. Ингэж сэглэхээ болимоор байна.

Ц.Даваасүрэн: Хариулъя. Тэр нийтийн, нийгмийн үйлчилгээ үзүүлж байгаа ашигтай ажиллах боломжгүй компаниудыг ингээд байж болох юм уу гээд байна шүү дээ. Хэн хариулах юм бэ, хэдэн номерын микрофон юм бэ? 8 уу, 8.

Д.Саруул: ЗГХЭГ Саруул. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийн шинэчилсэн найруулгыг, хуулийг шинээр боловсруулаад, ЗГ-аас саналд гаргаж байгаа. Ирэх долоо хоногоос юм уу өргөн барих асуудлууд яригдах байх. Харин энэ нөгөө төрийн өмчийн компани нь өмчийн шинэчлэлийн хүрээнд компаниудыг нэгтгэх, нийлүүлэх, мөн үр ашгийг нь үнэлэх асуудлууд бол ЗГ дээр хийгдэж байгаа.

Ц.Даваасүрэн: Энэ ажлын хэсэгт чинь Солонгоо дарга байсан уу, үгүй юү? Энэ тэгээд сайд нь ч байхгүй, Солонгоо нь ч байхгүй. Та нар ингэж байж яаж төсвөө батлуулах гээд байгаа юм бэ? Хүлээх үү? Хүлээе, тийм хүлээе. Хугацаа, одоо ирж л байгаа юм байна лээ. Тэгэхдээ ороод ирнэ, тэгэхээр нь асууя. 2 дарга ороод ирлээ. Ганхуягийн Төрийн өмчийн хорооныхыг нь Солонгоо дарга хариулъя. Манай ЗГ-ын хэд маань өөрсдөө анхаарахгүй бол бүр цаг нэлээн яваад байна шүү. Өөрсдөө хичээж, төсвөө батлуулахгүй бол. Тэр Ганхуяг гишүүний асуусан тэр төрийн өмчийн компаниудыг 3 жил дараалан алдагдалтай ажиллавал татан буулгах гэсэн нэг хуулийн төсөл байгаа шүү дээ. Түүнтэй холбогдуулаад асуусан байна лээ. 1 номерын микрофоныг өгье.

Б.Солонгоо: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Тэгээд ТББХ-ны хурал давхацсан учраас уучлаарай оролцож чадсангүй цагт нь. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төрийн өмчит компаниудын үр ашигтай үйл ажиллагааг сайжруулах, засаглалыг ил тод, нээлттэй болгох чиглэлээр хуулийн төсөл боловсруулсан. Тэгээд үүнтэй холбогдуулаад 3 жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн тохиолдолд тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах эсхүл татан буулгах асуудлыг хөндсөн. Гэхдээ энэ бол шууд татан буулгана гэсэн үг биш. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага саналаа ЗГ-т хүргүүлнэ гэж томъёолсон байгаа. Тэгэхээр тухайн хуулийн этгээдийг.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 номерын микрофон дахиад өгчихье, гүйцээлгэе хариултыг.

Б.Солонгоо: Тэгэхээр тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг үр ашигтай ажиллуулах чиглэлээр өөрчлөн байгуулах юм уу эсхүл татан буулгах юм уу гэдэг саналаа ирүүлнэ. Үүн дээр үндэслээд ЗГ-аас шийдвэр гаргахаар байгаа. Мэдээж үр ашиггүй ажиллаж байгаа, алдагдалтай ажиллаж байгаа компаниудын судалгааг хийсэн. Тэгээд судалгаанаас аваад үзэхээр дийлэнх нь энэ авто замын засварын компаниуд байгаа. Тэгэхээр эдгээр компаниудтай холбогдуулаад цаашид бол нэгтгэх, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах дээр анхаарч ажиллаж байгаа.

Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв төрийн өмчит үйлчилгээний газрын хувьд өөр байгууллагатай нэгтгэх замаар үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах ажил бол хийгдэж байна. Тэгэхээр цаашдаа анхаарч байгаа асуудал

бол ерөөсөө санхүүгийн үр ашигтай байдлыг сайжруулах, энэ хүрээнд сахилга батыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, үргэлжлүүлээд.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Солонгоо дарга ингэсэн юм. Нийгмийн чиг баримжаатай шахуу нөгөө ашиг олоход хэцүү үйл ажиллагаа явуулдаг ийм төрийн өмчийн компаниудыг бас ингээд татан буулгаад байх юм уу гэж асуугаад байсан байхгүй юу. 1 номерын микрофоныг, 1 номерыг өгье. Тарифыг нь жишээлбэл ингээд төрөөс барьчихдаг ч юм уу ингээд байвал яах юм бэ? 1 номерын микрофоныг өгье. Болохгүй байна уу, 2-ыг өгөх юм уу тэгвэл. 1 номер. Энэ яагаад бүр бүгдийг нь гаргачихлаа шүү дээ яаж байгаа юм бэ? 1 номерын микрофон өгье, тэнд гацаад л байгаа юм шиг байна. 2-ыг өгье тэгвэл, 2 номерын микрофон. 1 чинь ирчихлээ, 1 дээр.

Б.Солонгоо: Алдагдалтай ажиллаж байгаа компаниудын хувьд бол сүүлийн 3 жилээр 22 хуулийн этгээд байгаа. Мэдээж үүн дотроос нийгмийн зайлшгүй үйлчилгээг үзүүлж байгаа, нөгөө талаараа дэд бүтцийн суурь үйлчилгээг үзүүлж байгаа компаниуд орсон. Ялангуяа дулааны станцууд болон дамжуулах шугам сүлжээний компаниуд байгаа. Тэгэхээр мэдээж эдгээр компаниудын асуудлуудыг бол шууд татан буулгаж бол шийдвэрлэх боломжгүй. Гэхдээ нөгөө талаараа бид нарын зайлшгүй анхаарах ёстой зүйл бол эдгээр компаниудыг үр ашигтай ажиллуулах чиглэл дээр юун дээр анхаарах юм бэ гэдэг дээр 3 жил тутам санал авч, ЗГ дээр тодорхой арга хэмжээнүүдийг шийдвэрлэхтэй холбогдуулаад энэ хуулийн төсөл орж ирж байгаа.

Тэгэхээр бол нийгмийн шинж чанартай үйл ажиллагаа явуулж байгаа суурь дэд бүтцийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хувьд бол мэдээж өөрийн гэсэн онцлог байгаа. Тэгэхээр үүн дээр бол тухай бүр нөхцөл.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Батжаргал дарга асуултаа асууя, гишүүн.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая. Төсвийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн хууль тогтоомжуудыг үзэл баримтлалынх нь хувьд хэлэлцэхийг дэмжиж байгаа юм. Гэхдээ хэд хэдэн зүйл байна. Улсын Их Хурал дээр 2025 оны төсөв бараг үндсэндээ 100-гаад хоног хэлэлцэгдлээ яг нарийндаа. Тийм учраас энд яригдаад байгаа ийм 2 үндсэн том санаа яваад байх шиг байна гэж. Энэ дунд хугацааны хөгжлийн зорилтуудаа хангах тал дээр гишүүд нэлээн их санаа зовоод байгаа. Яриад байгаа юмыг нь харахаар зэрэг. Тэгэхээр зэрэг энэ ЗГ-т чиглэл өгч байгаа тогтоол дотроо энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтуудаа хангах арга хэмжээний чиглэлээр их тодорхой чиглэл өгөх нь зөв. Тэр мега 14 төсөл, энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, энэ улс орны хөгжлийг урагшлуулах тэр том зорилтуудаа хангах чиглэлээр бүхий л арга хэмжээг авч ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх энэ тэр гээд олон арга хэлбэрүүдийг ашиглах талаар нэг тодорхой чиглэл өгөх ёстой болов уу гэсэн нэг ийм бодол байна.

2 дахь зүйл ерөөсөө яригдаад байгаа юм энэ төрийн зардал их нэмэгдсэн, төсөв их данхайсан гэдэг юм яригдаад байгаа. Уг үндсээр нь авч үзэхээр хэд хэдэн зүйл л яригдаад байгаа. Тэгэхээр үүнийг бол бүгдийг нь нэг удаагийн амьсгаагаар шийдэх боломжгүй. Тэгэхээр нэлээн ул суурьтай дүн шинжилгээ хийх шаардлагатай болчихоод байгаа юм. Төрийн чиг үүрэг, бүтэц, тэгээд төрийн нуруун

дээрээс ачааллыг хөнгөлөх, хувийн хэвшил рүү шилжүүлэх боломжтой салбар үйл ажиллагаанууд энэ тэр гээд олон зүйлүүдийг бид ярьж байж энэ төсвийн зохистой бүтцийн асуудал яригдаж гарч ирэх болов уу гэсэн ийм бодол байгаа. Энэ дээр нэлээн томоохон ул суурьтай судалгаа, дүн шинжилгээ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ саналыг 26 оны улсын төсөв өргөн барихынхаа алдад ч гэдэг юм уу оруулж ирэх талаар чиглэл өгч байж бид энэ нэг яригдаад байгаа төсвийг зохистой болгох асуудал, энэ өсөлтийн хурдцыг хязгаарлах асуудал бий болох болов уу гэсэн нэг ийм л санаа байгаад байгаа юм. Энэ 2 зүйлийг тэр ЗГ-т өгч байгаа чиглэлийн шийдвэр дотроо оруулах нь зөв болов уу гэж.

Тухайлсан ганц нэг асуудал байгаа юм. Үнэхээрийн бид энэ үйлдвэрлэл үйлчилгээгээ дэмжье, үйлдвэрлэгч улс орон болъё гэдэг зорилтынхоо хүрээнд үйлдвэрийн тоног, төхөөрөмжүүдийн гаалийн албан татварыг хөнгөлөх тухай, чөлөөлөх тухай асуудал дагаж хуулиар орж ирсэн. Үүн дотор бол энэ ХАА-н үйлдвэрлэлийнхээ онцлогийг харгалзаж, ХАА-н үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа хөдлөх боловсруулах үйлдвэрлэл гэдэг юм уу даа бараг үндсэндээ энэ газар тариалангийн үйлдвэрлэлийн комбайн гээд эднүүсийг энэ зохицуулалт дотор хязгаартай багтааж оруулах талаар хэлэлцүүлгийн түвшинд анхаарах нь зохистой болов уу гэсэн нэг ийм бодол байна. Үүнийг хэлэлцүүлгийн түвшинд нь анхаарах ёстой байх гэж.

Дараагийн нэг зүйл энэ Төрийн хэмнэлтийн хууль, тэгээд төсөв батлагдсантай холбогдуулж авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ эд нарынхаа юмнуудыг хэдүүлээ хэлэлцүүлгийнхээ түвшинд нэг харах ёстой болов уу гэсэн нэг ийм бодол байгаад байх юм. Үнэхээрийн хусмаа голж байгаа хүүхэд шиг юм яриад хэрэггүй л дээ. ЗГ-таа бид бүхэн тодорхой чиглэл өгөөд, яг тэр дагуу нь төсвийг нь боловсруулаад, дахин өргөн мэдүүлэх ч гэсэн бид хэдийн хүсээд байсан тэр хэмжээнд боловсрогдож орж ирсэн. Одоо Их Хурал өөр дээрээ сайжруулах зохицуулалтынхаа юмыг л хийх ёстой гэж ингэж.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд хариулах уу.

Б.Жавхлан: Гишүүдийнхээ өглөөний мэндийг эрье. Юун түрүүнд хоцорчихлоо уучлаарай, гишүүдээс уучлалт хүсэж байна. Батжаргал гишүүний хэлж байгаа тэр ойлгож байгаа. Тэр бид хувийн хэвшлээ дэмжвэл дэмжсэн шиг, гэхдээ их ойлгомжтой, тодорхой энэ татварын хөнгөлөлт энэ дэмжлэгүүдээ гаргах ийм бүр яг тулчихсан цаг мөч юм. Өөрөөр хэлбэл бид төсөв дээрээсээ төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардал гээд нэлээдгүй хумилаа. Тийм учраас нөгөө талдаа хувийн хэвшлийнхнийгээ маш сайн дэмжиж, энэ орон зайн дээр эдийн засгийнхаа өсөлтийн дэмжлэгийг сааруулахгүй байх хэрэгтэй. Энийгээ их сайн хүчтэй явуулж байж. Тийм учраас ААН-ийн орлого болон татвар мөн гаалийн албан татвар дээр хөнгөлөлтүүд орж ирж байгаа. Түүн дотор манай ХАА-н салбар, ялангуяа тариалангийн салбарынхан орхигдчих ийм утга агуулга байна гэж гишүүд хэлж байгаа. Энийг хэдүүлээ хэлэлцүүлгийн шатдаа анхааръя.

Байшин дотор хийгдэх үйлдвэрлэл, манай газар тариалан бол ингээд л хөрс боловсруулах хаврын ажлаасаа эхлээд л эцсийн бүтээгдэхүүн үр тариагаа хадгалах хүртэл үйлдвэрлэл нь ингэж явж байдаг. Тийм учраас энийг бас их зөв тодорхойлоод, аль болох орхигдуулахгүй бүхий л яг үйлдвэрлэлийн боловсруулах шат шатны салбаруудаа оруулъя гэж бодож байгаа. Тэгээд ажлын хэсэг дээрээ хэдүүлээ томъёоллоо сайн ярилцъя.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүн асуух уу.

Г.Дамдинням: Энэ гишүүд ер нь бүгдээрээ л яриад байгаа. Бүгдээрээ ер нь бас өнгөрсөн парламентаас хойш л ярьж байгаа. Энэ төрийн өмчит ААН-үүдийн тухай хуулийг ЗГ яаралтай оруулж ирж л хиймээр байна. Их олон асуудлууд байгаад байдаг. Жилийнхээ орлогыг багаар төлөвлөөд, олж ирсэн орлого нь илүү гарахаар зэрэг нь урамшуулал авдаг, үр өгөөж нь гардаггүй, нийт дүнгээрээ харвал ашиггүй ажилладаг ийм л байдал руу орчхоод байгаа юм. Тэгэхээр бид нар нэгэнт ийм маш хатуу тэлэх ямар ч боломжгүй төсөв батлах руугаа орчихлоо. Тэгэхээр бид нар хөрөнгө оруулалт, эх үүсвэрийг шинээр бий болгох ёстой. Тэгэхээр энэ чиглэлд Сангийн яам маань нэлээн Эдийн засгийн хөгжлийн яамтайгаа Засаг маань нэлээн ажиллах хэрэгтэй байгаа юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудаа бид нар нэг тийш нь шийдчихмээр байна. Үүнийг дагаад Ашигт малтмалын тухай хууль гээд их олон хуулиудад хөрөнгө оруулалтыг дэмжсэн заалтууд бид нар оруулж өгөх ёстой юм. Яах вэ энэ 4 жилдээ бидэнд итгээд хуулиа өөрчиллөө гээд орж ирэх хүмүүс байхгүй ч гэсэн олж ирэх талаас нь бүгдээрээ хичээж ажиллах ийм л зайлшгүй шаардлага бид нарт тулгарчихлаа. Тэгэхгүй бол 15 настай хүүхдийг 17 настай хүүхдийн гутал өмсүүл гээд л чихээд байна л даа бид нар. Эдийн засаг нь томормоор байдаг, жижигхэн хүлээс дотор барьчхаад л ингээд л хөдлөхгүй яваад байгаа байхгүй юу. Тэгээд энэ маягаараа 4 жил явбал эдийн засаг хэрхэн томрох юм бүү мэд. Тэгээд би ЗГ энэ үйл ажиллагааны жилийн ажлын улсын жилийн төлөвлөгөө энэ тэрээ биелүүлж чадах юм уу? Их л хэцүү дээ. Тэгээд би байнга хэлж байгаа. Энэ алдагдалгүй төсөв чинь тэгээд бид нарыг барьчихаж байгаа шүү. Тэгэхээр бусад эх үүсвэр лүүгээ л яаралтай шилжилт хийцгээе л гэдэг ийм юм ярьж байгаа. Энэ дээрээ та хэд маань нэг жоохон шуурхай ажиллаарай гэж.

2 дугаарт Дарханы замын ажил үндсэндээ ингээд дуусах шат руугаа дөхөж яваа. Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банкны их том зээлээр бид нар ингээд хийгээд, хэлтэй амтай арай гэж нэг юм ард нь гарч явна. Баруунхараагийн гүүрний санхүүжилтийн асуудал ер нь яаж байгаа вэ? Тухайн үед нь яагаад ч юм бүү мэд зураг нь ч байхгүй, төсөв нь ч байхгүй Баруунхараагийн наад талын нэг гүүрийг таг мартчихсан байдаг байхгүй юу. Тэгээд сүүлд нь манай энэ Сангийн сайд энэ дээр нэлээн анхаарал тавиад, араас нь хөөцөлдөөд ингээд явсан. Бид нар Улсын Их Хурлын ажлын хэсгээрээ нэлээн ажиллацгаасан. Тэгээд сүүлийн үед энэ дээр айхтар мэдээлэл сонсогдохгүй болоод байна. Энэ дээр нэг тодруулга өгөөч.

3 дугаарт өчигдөр хэлэлцэх эсэх ярьж байхад энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам Дархан руу нүүж байгаатай холбоотой мэдээлэл яригдаж байхад Хүнс, хөдөө аж ахуйн яамны сангуудын харьяа байгаа газар, үл хөдлөх хөрөнгүүд, Улаанбаатар хотын үнэ цэнтэй газруудад байгаа юмсыг зарж борлуулаад орон сууц болгох ийм юм яригдаад байгаа байхгүй юу. Энэ хэзээ ЗГ-ын шийдвэр гарсан юм бэ, ямар шийдвэр гарсан юм бэ, ямар үнэ өртөгтэй, хөрөнгөтэй юмыг яаж борлуулах гээд байгаа юм бэ, хэн авах гээд байгаа юм бэ? Их сонин ярианууд энэ социал орчинд яригдаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг хариу өгчихмөөр байна. Тодруулаад асуухаар хувь дээрээ хүлээж аваад их гомдоод байх шиг байна лээ. Гомдох юм байхгүй шүү дээ. Эсвэл гомдох юмтай байгаад байгаа юм болов уу,

гайхаад байгаа зарим сайд нарыг. Тэгэхээр энэ дээр манай энэ хөрөнгө мэдэж байгаа газрынхан нэг хариулт өгчхөөч. Тэгээд тодруулна.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Хөдөө аж ахуйн яамнаас хүн байхгүй юу? ЗГ-аар нэг сар, Дамдинням гишүүний асуултад хариулъя. Сар гаруйн өмнө Хөдөө аж ахуйн яам, ТӨБЗГ-аас хамтарсан тогтоол оруулаад, Хөдөө аж ахуйн яамны харьяа байдаг хэд хэдэн объектуудыг зарж борлуулаад, тэгээд Дархан-Уул аймагт тус яамны төрийн албан хаагчид болон харьяа агентлаг, газруудын төрийн алба, тийшээ нүүж байгаа төрийн албан хаагч нарыг амьдрах орон сууцаар хангах зорилгоор тэнд орон сууц худалдаж авах эх үүсвэрт нь зориулъя гээд шийдвэр гарсан байгаа. Тэгээд процесс явж байгаа. Тэрнээс хойш хэрхэн зарж борлогдсон процесс ямар байгааг сайн мэдээлэл алга байна. Яамнаас хүн байна уу? ТӨХ-ноос хүн байна уу? Тийм ер нь бол ЗГ-аас тийм шийдвэр гарсан юм. Харьяа объект барилгуудыг Улаанбаатарт байдаг зарж борлуулах, тэгээд эх үүсвэрээр нь орон сууц худалдаж авах гээд. Тэгэхдээ орон сууц худалдаж аваад төрийн албан хаагч нарт хувьд нь эзэмшүүлэх юм биш шүү. Тэр юу бол төрдөө байна, тэгээд тийшээ нүүж очсон төрийн албан хаагчдаа тэнд түр гэх юм уу, амьдарч оршин суух ийм боломжоор хангах зорилготой.

Ц.Даваасүрэн: Дарханы зам нөгөө нэг биш ээ, нэг гүүр байсан.

Б.Жавхлан: Тийм. Уучлаарай, гишүүний асуултад гүйцээж хариулъя. Яг Дарханы зам дээр тэр Баруунхараагийн нэг талын гүүр нь шинэчилж барих тэр ажлууд үнэхээр орхигдчихсон байсан юм байна лээ. Тэр хаанаа ч юм маш хариуцлагагүй хандсан байна лээ. Тэгээд 4 дүгээр хэсгийн байх, 4 дүгээр хэсгийн анх гэрээлэгч гүйцэтгэгч компани нь гэрээ нь цуцлагдсан, барьцаа хөрөнгөд байсан хөрөнгө манай талд хураагдсан гэх үү дээ гэрээний дагуу. Тэр эх үүсвэрээр гүүрний барилгын ажлыг хийхээр шийдсэн байгаа. Түүн дээр нэмэлт мэдээлэл өгөөдөх, 6 номер уу, 7 номер уу?

Ц.Даваасүрэн: 7.

Ж.Дэлгэржаргал: Дэлгэржаргал Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар. Өмнөх гүйцэтгэгчийн гэрээ цуцалсантай холбоотой гүйцэтгэлийн баталгааны 2,5 сая долларыг захиалагч талд энэ хөрөнгийг ашиглах ийм эрхийг, зөвшөөрлийг АХБ-аас өгсөн байгаа. Тэгэхээр Хараагийн, Хараа голын гүүрний хувьд бол нөгөө зураг төсөлд анхнаасаа байгаагүй гэдэг дүгнэлт, орхигдсон гэдэг дүгнэлт гарсан. Үүнтэй уялдуулаад Зам, тээврийн яам, Азийн хөгжлийн банк хамтраад энэ 2,5 сая долларыг тэр гүүрийг барих хөрөнгөд зарцуулахаар ийм процессын ажлууд хийгдээд явж байгаа.

Ц.Даваасүрэн: Тодруулъя, Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Тэгээд яах вэ 1 дүгээрт Дарханы зам 2,5 сая доллароор гүүр барина ч гэж байхгүй байх л даа. Тэгээд эх үүсвэрийг нь ер нь та хэд маань хаанаас, яаж босгоё гэж байгаа юм бэ? 2,5 сая нь бодвол зураг төслийг нь хийгээд, тэгээд л нэг эхлүүлээд л дуусах байлгүй дээ. 10 тэрбум орчим төгрөгөөр тэр гүүрийг барьж дийлэхгүй шүү дээ. Хүрэхгүй байх бараг. Тэгэхээр энэ зураг

төсвийнх нь хэмжээ хэд болж байгаа юм бэ? Хэдийд ер нь дуусгая гэж байгаа юм бэ? Энэ дээрээ нэг тодорхой хариулт хэлчихмээр байна.

2 дугаарт тэр Хөдөө аж ахуйн яамны төрийн өмчийг зарж борлуулаад, тэгээд орон байр аваад болдог юм болов уу? Энэ чинь нэг л аюултай сонсогдоод явчихлаа шүү наадах чинь. Хүний, энэ чинь төрийн өмч тэгээд л нэг ийм тааллаар шийдэгддэг юм байж болохгүй шүү дээ. Энэ дээр та нар нэг тодруулга өгөөч? Тэр 8 номерт түрүүн гараа өргөөд байх шиг байсан. Тэрнээсээ хариулт аваадахья даа.

Ц.Даваасүрэн: 8 номерт нэмэлт тодруулга авъя гэнэ.

Д.Саруул: ЗГХЭГ Саруул. Ерөнхийдөө ХААЯ-ны үл хөдлөх хөрөнгөд бүртгэлтэй байгаа энэ хөрөнгө нь болохоор Алтандорнод Монгол компаниас өрөнд авсан ийм үл хөдлөх хөрөнгө байгаа. Энийг болохоор тодорхой хэмжээнд эдийн засгийн эргэлтэд оруулаад, ХААЯ-ыг шилжин байршсантай холбоотой тэнд бол ажиллах нөхцөлийг хангахад зориулах энэ шийдвэрийг болохоор ЗГ-аас 2 мянга, тийм өнгөрсөн 10 сард, 10 сарын 30-ны өдөр гаргасан 152 дугаар тогтоолоор гаргасан. Тэгээд энэ хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар зохион байгуулна. Тэгээд ТӨБЗГ дээр бол ажлын хэсэг гараад бол ажиллаж байгаа.

Ц.Даваасүрэн: Тэр нөгөө гүүрийг 2,5 сая доллар хүрэхгүй, тэгээд энийгээ нэмэлт хөрөнгийг нь яаж зохицуулах вэ гээд 7 номер.

Ж.Дэлгэржаргал: Тэгэхээр эх үүсвэр нь бол бид нар яг тэр гүйцэтгэлийн баталгаанд авсан байсан 2,5 сая долларыг энэ гүүрний барилгын ажилд зарцуулна. Зам, тээврийн яамнаас бол зураг төсөв нь гарсан. Яг энэ санхүүжилтдээ багтана гэдэг ийм бичиг ирүүлчихсэн байгаа. Тийм учраас дараагийн процессын ажлууд хийгдээд явж байгаа.

Ц.Даваасүрэн: Дутуу хариулсан бол 1 минут, Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Тэр Дарханы замыг ойлгочихлоо. Тэр ХААЯ-ны тэр тариа, Хөдөө аж ахуйн корпорацын газар чинь миний бүр их дээр сонсож байснаар хураагдахдаа 22 тэрбум төгрөгөөр л зөвхөн нэг хэсэг нь ирсэн гэж сонсогдож байсан юм. Энэ Яармагийн гүүрний наад тал дээр байдаг Хөдөө аж ахуйн корпорацын нэг байр объектууд байж байгаа байх. Тэгээд тэр цаана MSM гээд компани байдаг. Тэрний цаана байдаг газрууд байгаа байх наадах чинь өчнөөн тэрбумын юм яваа шүү дээ. Тэгээд төрийн өмчийг ингээд орон байр болгох тухай, тэгээд л нэг ийм гэнэт нууцаар ингээд шийдэж болдог юм болов уу? Үнэ мөнгийг нь та нар нэг хэлээдхээч. Баланс дээр байгаа үнэ нь хэд юм бэ, яаж авсан юм бэ, зах зээлийн үнэ нь хэд болчихсон юм бэ, хэдээр зараад юу авах гээд байгаа юм бэ, ямар компаниас авах гээд байгаа юм бэ? Тодорхой хариулчихмаар байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: 8 номер хариулъя.

Д.Саруул: Хөрөнгийн үнэлгээний хувьд бол хөндлөнгийн үнэлгээний компаниар бол хийлгэсэн юм байна лээ. Одоогоор яригдаж байгаа юм бол 58 тэрбум төгрөгийн өртөгтэй хөрөнгө яригдаж байгаа. Тэгэхээр энийг зөвхөн түрүүний Жавхлан сайдын тайлбарладгаар орон сууцад зориулж байгаа биш, шилжин байршиж байгаа ХААЯ-ны өөрийнх нь хэвийн үйл ажиллагаа явуулах тэр

байрших байранд бол зориулахаар байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн өөрийнх нь мэдэлд байгаа ялангуяа ЗГ-ын өөрийн шийдвэрлэх энэ үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах энэ асуудлыг бол ЗГ өөрөө шийддэг ийм эрх хэмжээтэй байгаа хуулиараа.

Ц.Даваасүрэн: Тэгээд тэр нэмэлт мэдээллийг Дамдинням гишүүнд өгүүлчхээрэй. Тэр баланс дээр байгаа үнийг нь. Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Энэ өдрийн мэндийг хүргэе. 3, 4 тодорхой асуулт байна. Энэ Нэгжийн тухай хууль дээр байж байгаа 12 сарын 5-ны дотор орон нутаг төсвөө батлах ёстой улсын төсвөө баталсны дараа. Одоо ингээд төсөв тодорхой хэмжээнд хойшилж байгаатай холбоотой орон нутгууд руугаа яг ямар чиглэл өгч байгаа яах вэ? Хэрэг эрхлэх газраас буюу мөн Сангийн яамнаас түр хойшлуулах бичиг оччихсон байна лээ. Энэ очсон бичиг маань өөрөө энэ Нэгжийн тухай хуулиас давсан эрх зүйн акт болж чадах юм уу? Тийм учраас энэ дагаж орж ирж байгаа хуулиуд дээрээ энэ Нэгжийн тухай хуулийн заалтыг хөндөж орж ирж байгаа юу гэсэн 1 дүгээр асуулт.

2 дугаарт бид нар өнгөрсөн хугацаанд энэ Уул уурхайн бүтээгдэхүүний бирж, бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах тухай хууль маань их амжилттай явсан. Монгол Улсын эдийн засагт тодорхой хэмжээний мэдэгдэхүйц үр нөлөө үзүүлсэн. Энэ цаашдаа энэ Биржийнхээ тухай хуулийг хэрэгжүүлээд, уул уурхайн бүтээгдэхүүнээ биржээр борлуулах дээр тууштай яг үүгээрээ баймаар байгаа юм. Энэ маань зөвхөн манай улс битгий хэл сая бид нар өчигдөр Ганхуяг гишүүн хэлж байна лээ. Казахстаны парламент дээр манай Биржийн тухай хууль маш сайн туршлага болж яригдаад, тэднийх чинь парламент дээр энэ хуулийг өргөөд барьчихсан, одоо батлагдах шатдаа явж байгаа юм байна. Газ, нефть бусад уул уурхайн бүтээгдэхүүнийг Монгол улс шиг бид нар биржээр арилжаалах ёстой юм байна гэж хүртэл яригдаж байгаа. Гэтэл бид нар ийм сайн жишээ гаргаж ирчхээд болохгүй байна гээд ганц, хоёр зүйл дээр ухарч ерөөсөө болохгүй. Тийм учраас энэ дээр яг ямар бодлого барьж байгаа вэ Ганбат дарга?

3 дахь асуулт маань энэ тойрогтой холбоотой асуулт асуучихъя энэ төсөв явж байгаа үед. Манай аймагт энэ сая сүүлд өргөн барьснаар орж ирсэн төсвийн жагсаалт энэ дотор байж байгаа. Дэлгэржаргал дарга энэ манай Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 7 дугаар баг буюу Хотгорын уурхай дээр байдаг баг дээр нэг эмнэлгийн барилга 2019 онд эхэлсэн юм. Бид нарыг намайг сонгогдохоос ч өмнө эхэлчихсэн асуудал. Гэтэл Хотгор баг маань өөрөө яг уул уурхай дээр ажилладаг, байнгын уул уурхайн осол, тэнд амьдарч байгаа 300 гаруй иргэдийн эрүүл мэндийн асуудал. Энэ маань хэдий Өлгий аймгийн төвийн сумын нэг баг боловч аймгийн төвөөсөө 140 гаруй километр алслагдчихсан. Тэр болгон түргэн дуудлагын машин ирээд байж болдоггүй. Эмнэлэг зайлшгүй хэрэгтэй. Байнгын тэнд утаатай, нөгөө нүүрсний ато... энэ тэр шатахаар байнгын утаа угаартай, эрүүл мэндийн үйлчилгээ авах зайлшгүй ийм шаардлагатай. Тэнд амьдарч байгаа нэг хүн боловч энэ төрөөс эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй шүү дээ.

Тийм учраас энэ төсвийн жагсаалт дотор Хотгор дээр баригдаж байгаа эмнэлгийн жагсаалт ор тас алга болчихсон байх юм. Энэ чинь дуусаагүй барилга явж байдаг, хойшлуулж байгаа тэр магадлан хийлгээд 2019 оны төсөв юм байна лээ. Магадлан хийлгээд ирэх жил ч болтугай авчихмаар байна гэж байгаа. Одоо барилга нь баригдаад яг нэг ийм хэмжээнд ингээд нэлээн явчихсан байдаг.

Энийгээ ядаж 50 сая төгрөг суулгаад болтугай энэ 25 оны улсын төсөв дээр суулгахгүй бол ор тас алга болчихдог, 26 онд үгүй ээ наадах чинь хаанаас гараад ирэв гээд ийм асуудал үүсчих вий дээ. Энийг нэг тийш нь тайлбарлаад өгөөч гэж.

4 дэх асуулт маань түрүүн Ганбат дарга хариулчхаж байна лээ. Энэ төв цэвэрлэх байгууламж буюу усыг гүн цэвэршүүлэх байгууламж 2 чинь 2 тусдаа объект. Усыг гүн цэвэршүүлэх барилга байгууламж нь болохоор Америкийн болон Монголын ЗГ-ын хөрөнгөөр баригдаж байгаа. Яг төв цэвэрлэх байгууламж маань Хятадын тусламжаар баригдаж байгаа боловч энэ төв цэвэрлэх байгууламжийг чинь ашиглалтад оруулахгүй бол нөгөө гүн цэвэрлэгч нь орохгүй юм байна лээ. Тийм учраас энийг энэ удаагийн улсын төсөв дээр анхаарахгүй хаяж хэрхэвч болохгүй. Нөгөө Америкчууд чинь ирэх оны 3 сар гээд шууд гараад явчих юм байна лээ шүү дээ. Энийг чинь төв цэвэрлэх байгууламж нь ашиглалтад орохоор гүн цэвэрлэхтэйгээ нийлүүлээд, нэг юунд оруулаад, стандартын дагуу ингээд усыг нь цэвэршүүлж барих зөндөө ажил хийгдэх ёстой юм байна лээ. Тийм учраас ирэх жилийнхээ улсын төсөв дээр энэ төв цэвэрлэх байгууламжийнхаа юуг нэг анхаараад явах нь дээр байх. Хэдий Хятадын тусламж боловч. Тийм учраас энэ төв цэвэрлэх байгууламжийн асуудлыг Ганбат дарга нэг хариулаад өгчих үү? Дэлгэржаргал дарга тийм нэг асуулт Хотгорын.

Ц.Даваасүрэн: Тэр сүүлийнх нь нөгөө саарал усны асуудал хариулъя асуугаад байх шиг байна. Жавхлан сайд эхлэх юм уу? Жавхлан сайд хариулъя. Тэгээд дараа нь ажлын хэсэг нэмээд явчихъя.

Б.Жавхлан: Аубакир гишүүний асуултад хариулъя. Нэгжийн тухай хууль дээр ийм юм байна лээ гишүүнээ. Хоригтой холбоотой эсвэл хууль хүчингүй болсонтой холбогдуулаад хэлэлцэх тийм цаглавар зохицуулалт байдаггүй юм байна. Тэгээд харин сая бид нар Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар тэр зохицуулагдаагүй орон зайнуудыг их сайн ойлгомжтой болгочихлоо гэж харж байгаа. Тийм учраас зөрчилдөх зүйл байхгүй. 12 сардаа багтаагаад орон нутаг хуулиудаа батлаад явахад бол асуудал байхгүй.

Бирж дээр бол одоо Биржийн хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Энэнийхээ дагуу бүх борлуулалтууд явагдаж байгаа тийм.

Ц.Даваасүрэн: 7 номер, Дэлгэржаргал тэр юунд нь хариулчихъя нөгөө хөрөнгө оруулалт тэр нэг баг дээр байгаа эмнэлгийн.

Ж.Дэлгэржаргал: Баян-Өлгий аймгийн Хотгор сумын багийн эмнэлгийн хувьд бол 19 онд эхэлсэн. 24 оны хууль дээр 1 тэрбумын өртөгтэй, энэ жил санхүүжих дүн нь бол 758 сая төгрөг байгаа. Тэгэхээр энэ төсөл хуулиараа 24 он руу шилжихгүй. Өөрөөр хэлбэл гэрээний үлдэгдэл байхгүй. Ямар асуудал байгаа вэ гэхээр төсөвт өртгийн нэмэгдэл байгаа.

Ц.Даваасүрэн: 25 он руу юу?

Ж.Дэлгэржаргал: Тийм, үлдэгдэл байхгүй. Төсөвт өртгийн нэмэгдэл байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид нар төсөвт өртгийн нэмэгдлийн санхүүжилтийг бол огт аваагүй буюу Их Хурлын тогтоолын дагуу аудит хийлгээд, аудитын дүгнэлтэд үндэслээд 25 оны 1 дүгээр улиралд саналаа Их Хуралд танилцуулна.

Төв цэвэрлэх байгууламжийн хувьд бол Хятад улсын Эксим банкны хөнгөлөлттэй зээл 268 сая ам.доллар, ирэх жил дуусах ёстой. Тэгэхээр гол асуудал нь төв цэвэрлэхээс гарч байгаа бохирдол усны стандарт нь Мянганы сорилтын сангийн яг төв цэвэрлэхийн хажууд баригдаж байгаа 2 дахь үйлдвэрээр хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрийн стандарт хооронд зөрөө үүсээд байгаа гэсэн үг. Хүлээж аваад, боловсруул.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 7 номер нэмж, нөгөө саарал усны стандарт нь шаардлага хангахгүй байгаа юм байна тийм ээ? 7.

Ж.Дэлгэржаргал: Төв цэвэрлэхээс гарч байгаа хаягдал усны стандартыг Мянганы сорилтын сангийн бохир ус боловсруулах үйлдвэрийн стандарттай нэг болгох асуудал яригдаж байгаа гэсэн үг. Тэгэхээр Мянганы сорилтын сан талаасаа бол асуудал байхгүй. Гол нь Барилга, хот байгуулалтын яам яг энэ төв цэвэрлэхийнхээ стандартыг буюу яг хаягдал ус гарч байгаа үйлдвэрүүд дээр дахиж цэвэрлэх байгууламж барьж байж яг стандартаа нийлүүлэх асуудал байгаа. Энэ дээр бол Барилга, хот байгуулалтын яам дээр ажил хийгдээд явж байгаа. ЗГ-таа танилцуулаад шийдвэр гаргах. Тэгээд мэдээж цэвэрлэх байгууламжууд барихаар дахиад эх үүсвэрийн асуудал бас яригдаад байгаа.

Ц.Даваасүрэн: Аубакир гишүүн тодруулъя. Та ер нь байна шүү дээ Батсуурь сайдаас асуугаарай. Тэд нар нөгөө Ковидын үеийн үнийн зөрөө гээд дааж давшгүй мөнгө нэхээд байдаг байхгүй юу. Тэрнээс болоод ажил нь удаашраад, ажил нь удаашрангуут нөгөө Мянганы сорилтын сангийн хөрөнгө зарцуулах хугацаа нь дуусчих юм асуудал үүснэ. Тийм учраас та ер нь чуулган дээр тодруулах хэрэгтэй байх. Аубакир гишүүн тодруулъя.

Т.Аубакир: Дэлгэржаргал даргаа тэгвэл Хотгорын эмнэлгийн асуудал маань ирэх жилийн төсөв хэлэлцэх үетэй нь зэрэгцэж эхлээд, ингээд 27 он руу шилжчих нь байна шүү дээ бүр тийм ээ? 27 онд Өлгий сумын 7 дугаар баг буюу Хотгорын иргэд эмнэлэгтэй болох нь гэж ойлголоо шүү. 19 онд эхэлчихсэн барилга. Одоо тэр чинь тодорхой хэмжээний 2, 3 тэрбум төгрөг хийчихсэн хаялтай нь биш.

Тэр цэвэрлэх байгууламжийн асуудал бол сая хэлж байгаа нь Хятадын зээл гэсэн тийм ээ. Зээл чинь эргээд Монгол Улсын төсөв дээр хэдэн жилийн дараа ачаалал болоод л ирнэ. Тэр төсөвт өртгийн нэмэгдэл энэ тэр нь байдаг ч юм уу. Нөгөө талдаа энэ компакт гэрээний хувьд буюу Америкийн ЗГ, Монгол Улсын ЗГ хамтраад хийж байгаа энэ зүйл бол сүүлийн 30 жил энэ Улаанбаатар хотын цэвэр усны хангамжид хийгдэж байгаа хамгийн том хөрөнгө оруулалт. Зөвхөн Барилгын яам руу чихээд хаяхгүйгээр бид нар хаана хаана зайлшгүй анхаарах ёстой. Энэ ус, цэвэр усны нөөц, хэрэглээ, олборлолт юу болж байгаа билээ. Тийм учраас энийг зөвхөн Барилгын яам руу чихээд хаяхгүй.

Ц.Даваасүрэн: Тийм, энэ дээр бол цэвэр ус нь бол ашигладгаараа ашиглагдана, баруун эх үүсвэр. Хамгийн гол нь нөгөө нэг цэвэрлэх байгууламжаас гарч байгаа саарал усыг станцад ашиглах асуудал байгаа байхгүй юу. Тэр нь стандартын шаардлага хангах тухай асуудал яригдаад байгаа юм. Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: 2 асуулт байна. 1 дүгээрт энэ 25 оны төсвийг дагасан хууль дээр өмнөх хууль дээр хэлэлцэж байхад энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд ЗГ жагсаалт гаргаж, татварын хувь хэмжээ тогтоохоор төсөл орж ирээд, энэ маань бол Улсын Их Хурлын Үндсэн хуульд заасан татвар тогтоох онцгой бүрэн эрхэд халдсан байна, булааж авч байна гэдэг үндэслэлээр санал яригдаж, хэлэлцүүлгийн явцад энэ Улсын Их Хурал шийдвэрлэж байхаар баталсан. Энийг хориг дээр бол яригдаагүй шүү дээ. Ерөнхийлөгч бол энийг хориг дээр буруу, зөв гэж бол үндэслэл заагаагүй. Ингээд хориг хүлээж авагдаад, тэгээд ингээд буцаад ороод ирсэн чинь Их Хурал нөгөө шийдвэрлэж байх юм нь байхгүй болчихсон ороод ирчихсэн л байна буцаагаад. Тэгээд яг Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуулийг нь ингээд унших юм бол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар гэдэг ийм нэмэлт, өөрчлөлт орж ирсэн байна л даа. Би бол энэ зарчмыг нь дэмжээд байгаа шүү дээ. Татварын хөнгөлөлт үзүүлж, бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжих гэдэг энэ зарчмаа бол дэмжээд байгаа юм.

ЗГ өөрөө энэ татварын хувь хэмжээгээ түүгээрээ шийдвэрлэдэг байх энэ нь өөрөө болохгүй л гэдэг Үндсэн хуулийн шаардлага яриад байгаа шүү дээ. Одоо энэ оруулж ирж байгаа төслөөс ингээд унших юм бол өмнө нь оруулж ирсэн нөгөө ЗГ жагсаалт гаргана гэдгийг нь ч авчихсан, Их Хурал жагсаалт гаргана гэдгийг нь ч авчихсан байгаа байхгүй юу. Тэгэнгүүт энэ юу гэж уншигдаад байна вэ гэхээр энэ нэг татварын байцаагч түүгээрээ аль төсөлд, хэдэн хувийн татварын хөнгөлөлт үзүүлэхийг шийдэх гээд байгаа байхгүй юу татварын байцаагч. Тийм учраас ямар төсөл дээр татварын хөнгөлөлт үзүүлэх вэ гэдгийг татварын байцаагч шийдэх юм уу, өөрийнхөө үзэмжээр үү? Өөрийнхөө үзэмжээр, дур зоргоор гэсэн үг шүү. Тайлбарлаж, хууль тайлбарлаж татварын байцаагч татварын хөнгөлөлт үзүүлэх гэж байна.

Тийм учраас татварын хөнгөлөлт үзүүлэх асуудал бол нэн тодорхой байх ёстой. Нэн тодорхой, салаа утгагүй, 2 хүн 2 өөрөөр ойлгох боломжгүй бичигдэх ёстой. Тэгж байж энэ үзэмж дур зоргоос ангид байна, тэгж байж тодорхой байна, тэгж байж авлигаас ангид байна. Тийм учраас энэ асуудлыг тодруулж асууж байгаа юм.

2-т нь энэ Хөдөө аж ахуйн яамны харьяанд шинэ агентлаг байгуулах гэж байгаа юм байна л даа. Ургамал хүрээлэн гэнэ үү, Ургамал хамгааллын хүрээлэн. 500 сая төгрөгийн төсвийг 25 онд тавьж байгаа юм байна. Нэмэлтээ авчих уу даргаа?

Ц.Даваасүрэн: Энхбаяр гишүүний 1 минутыг өгчихье.

Б.Энхбаяр: Тэгэхээр энэ нэг талдаа бид нар чинь төр том болчихлоо, данхар болчихлоо, энэ дагасан хууль дээр жишээлбэл Төрийн хэмнэлтийн хууль дотор энэ олон зөвлөл, алба, төслийн нэгжүүд гэсэн энэ төрийн албаны тоонд ордоггүй, тэгсэн мөртөө энэ зөвлөлийн ажлын албууд чинь аягүй өндөр цалинтай юм байна лээ шүү. Их Хурлын гишүүдээс өндөр цалин авдаг юм байна лээ ажилтнууд нь. Тэгээд дураараа түүгээрээ байгуулчихдаг ийм нэгжүүдийг татан буулгая гэсэн санал орж ирж байгааг дэмжиж байгаа. Тэгтэл нөгөө талд дахиад агентлаг байгуулах гээд байгаа юм. Ургамлын хүрээлэн, юу агентлаг гэхээр энэ

ойн газраасаа ямар ялгаатай юм бэ? Бид нар чинь ойн агентлаг Байгаль орчны яаманд байгуулчихсан шүү дээ. Ургамал гэхээр өвс, өвсөө хариуцаж байна гэсэн үг үү. Модыг нь болохоор Байгаль орчны яам, өвсийг нь болохоор Хөдөө аж ахуйн яам хариуцах гэж агентлаг байгуулж байгаа юм уу? Энэ ямар учиртай юм бэ?

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Гишүүн тэр ААНОАТ-ыг одоо л яг ойлгож байх шиг байна. Бид хувийн хэвшлээ дэмжвэл дэмжсэн шиг дэмжих хэрэгтэй. Нэг талаараа дэмжээд байгаа юм шиг мөртөө нөгөө талаараа хааж боодог байж болохгүй Энхбаяр гишүүнээ. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар бүс бүрд ямар, ямар чиглэлээр тэргүүлэх вэ, тэр тэргүүлэх чиглэлээр нь орж ирж байгаа ААН-үүдийн үйлдвэрлэлийг нь дэмжсэн, боловсруулах шатных нь ААН-ийн боловсруулалтыг нь дэмжсэн ийм татвар орж ирж байгаа. Тэрийг татварын байцаагч тэндээ сумдаа л шийдчих хэрэгтэй. Хуулийг нь маш тодорхой ойлгомжтой гаргаад өгөхөөр.

Та болохоор Монголын ард түмэн сонсож байгаарай ЗГ дээр тэр нөгөө ААН-үүд ямар үйлдвэр барих гэж байна тэрийгээ тэнд жагсаагаад, тэгээд Их Хурал руу аваад ир, бид нар тэрийг чинь шийднэ гээд. Тэгээд 1 төсөл бичээд таны үүдэнд суугаад, энийгээ би татвараас хөнгөлүүлэх гэсэн юм гээд ингээд явж байх юм уу? Тийм ААН ирэх үү? Тэгэхээр бид нар нэгэнт бид нар төсөв дээрээ ийм таналт хийж байгаа үед төсвийн оролцоог эдийн засагт хувийн хэвшлээр илүү их түлхүү нөхөх энэ боломжуудыгаа тавих энэ дээр бол маш том ийм алхам болно. Тэр гаалийн албан татвар дээр ч гэсэн тэр. Одоо нэг гааль дээр нэг үйлдвэрийн технологийн тоног, төхөөрөмжүүд ирчхээд, Улсын Их Хурал дээрээс шийдвэр гаргахыг нь хүлээгээд тэр ААН-үүд тэр хил дээр очоод сууж байх уу?

Өмнөх тогтоол дээр 12 сарын 10-нд ЗГ жагсаалт оруулж ир гээд ингээд заачихсан байсан. Тэгээд ЗГ зарлах нь байна л даа. Энэ бүсүүдэд, аймгуудад үйлдвэр барих гэж байгаа энэ төслүүдээ аваад тэр хэн эзэмшиж байгаа юм, ямар үйлдвэр барих гэж байгаа юм бүгдийг нь энд авч ирж далан булчирхайг нь тоочиж байгаад, тэгээд энд шийдвэр гаргах юм уу? 126 татварын байцаагч, 126 гаалийн байцаагч болгох гээд байгаа юм уу Их Хурлаа. Тэгж болохгүй шүү дээ. Юмыг хэтрүүлнэ, хэтрүүлнэ гэхэд ингэж арай хэтрүүлж болохгүй. Тийм учраас ААН-үүдийгээ дэмжвэл дэмжсэн шиг ил тодорхой, ойлгомжтой байх хэрэгтэй.

Тийм учраас аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тэр чиглэлийн чиглэлийг нь заахдаа өмнө нь Улсын Их Хурлаар гаргачихсан тогтоол нь маш ойлгомжтой байгаа. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд. Бүс бүрд ямар чиглэлийн үйлдвэр ААН-үүд салбарууд нь тэргүүлэх байх вэ гэдгийг нь. Тэр хүрээндээ ороод ирж байгаа үйлдвэр ААН-үүдийн тэр дэмжлэгийг нь тэнд татварын байцаагч л шийдчихнэ. Маш ойлгомжтой байх хэрэгтэй харин. Ийм шийдвэр орж ирсэн юм байгаа юм.

Тэр ургамлынх бол хууль нь гарчихсан, хуулийн дагуу хийгдэж байгуулагдаж байгаа ийм агентлаг. Тэр 8 сард орхигдчихсон юм байна лээ. Тийм, тэр талаар заалтуудыг нь хэлээд өгөөч.

Ц.Даваасүрэн: Тэр нөгөө хөрс, ургамал судлал биз дээ? Малын бэлчээр, тийм үү? Гадаадад тэр ялангуяа ХАА-н орнууд тэр хөрс, ургамал судлалын

асуудлыг бол маш нарийн судалж байдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд тэр ургамал устахаар нь тэрийг нь тарьж ургуулаад л, тэгээд хамгаалаад тэгээд байж байдаг юм байна лээ. Энхбаяр гишүүн тодруулах юм уу? Сая тодруулъя гэсэн үү, үгүй юу? Тодруулъя гэсэн үү, үгүй юу? Тодруул, тодруул 1 минут.

Б.Энхбаяр: Жавхлан сайд та болиорой. ЗГ түүгээрээ шийддэгийг нь би энэ Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй байна гэсэн. Тэгсэн чинь та Улсын Их Хурал тэгвэл баталдаг болгоод өөрчилье гээд таны санал шүү дээ. Парламентын онцгой бүрэн эрх байна гэдэг асуудал хэлэнгүүт тэгвэл Улсын Их Хурал жагсаалтыг нь баталдаг болъё гээд та өөрөө чуулганы хуралдаанд хэлээд байсан шүү дээ. Тэгээд болгоод өөрчилчихье тийм ээ. Тэгээд одоо сая 2 долоо хоногийн өмнө ярьж байсан юмаа одоо болохгүй энэ 126 гишүүн ер нь татвар тогтоодог байж болохгүй гэж яриад байна шүү дээ та. Татварын байцаагч би хэлээд байна шүү дээ ямар төсөл дээр энэ хамаарах вэ, энэ хууль чинь хамаарах вэ гэдгийг татварын байцаагчийн дур зорго үйлчлэх гээд байна гээд байгаа шүү дээ. Тэрнээс би бүх нэр, компаниар нь би парламент баталдаг байх ёстой, хэлэлцдэг байх ёстой гэж би бол ерөөсөө санал гаргаагүй шүү. Та хариуцлагатай байна шүү. Тийм. Тэгэнгүүт.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энхбаяр гишүүнээ та өөрөө ядаж 2 сарын санамж ойтой байгаарай, ой санамжтай байгаарай. Өөрөө ямар санал гаргасан бэ гэхээр бүүр аж ахуйн нэгжээр нь, төслөөр нь оруулж ирээч гэж санал гаргасан шүү. Протокол дээр чинь байгаа. Харин би тэрийг чинь болио, ядаж салбараар нь, салбарынх нь жагсаалтыг оруулж ирье гэж ийм санал гаргаад, би өөрчлүүлсэн. Өөрийнх чинь бол бүр ААН ер нь бүр төсөл болгоноор нь шүү. Иргэн А, тийм компани, бүгдээр нь авчир гээд протоколд байгаа шүү Энхбаяраа.

Ц.Даваасүрэн: Энэ дээр маргалдаад, хэнд, юун дээр, ямар татвар тогтоох вэ гэдгийг Их Хурал шийдэх ёстой гэдэг л юм яригдсан тийм ээ. Тэгээд Их Хурал ер нь шийдье гээд энэ ч зөв шүү дээ. Энэ чинь Их Хурлын бүрэн эрх юм чинь, тэр компани ч, компани бол биш л дээ. Ер нь Их Хурлын бүрэн эрх. Юун дээр, ямар хэмжээний татвар ноогдуулах вэ гэдэг бол Их Хурлын бүрэн эрх шүү. Тийм учраас Их Хурал хууль батлаад байхад, тэгээд та нар тэрийг нь байхгүй болгоод орж ирж байдаг бол буруу байхгүй юу. Тийм учраас ажлын хэсэг дээр энийг эргэж анхаарна шүү. Ингээд маргалдаад байж болохгүй. Нөгөө төсвөө явуулмаар байдаг. Асуулт асууж дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүн байна уу? Алга байна, 2 байна. Батбаяр, Дамдинням гишүүнээр, Ганбаатар гишүүн, Мөнхтулга гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн үгээ хэлье.

Б.Энхбаяр: Би энэ татвар тогтоох асуудлыг Жавхлан сайд Сангийн сайд дур зоргоороо, үзэмжээрээ шийдвэрлэх асуудлыг би буруутгаж байгаа. Энийг бол Жавхлан сайд мэтийн хүмүүс бол өөрт ашигтай байдлаар ашиглана, энийг авлига болгож хувиргана. Тухайлбал одоо яригдаж байгаа Эрдэнэс Тавантолгойн Бортээгийн нүүрсний борлуулалтыг монопол байдлаар өгсөн Адмирал гэх энэ компанитай холбоотой 2 дахь тендерийн маргаан Сангийн яамд хянагдаж байх үед татгалзаад, тэр үйлдлийнхээ төлөө та Бортээгийн нүүрсний борлуулалтын монопол эрхийн 10 хувийг авсан байж болзошгүй үйлдэл нүүрсний сонсгол дээр яригдсан. Тийм учраас таныг гэрчээр дуудсан. Та орж ирчхээд, хариулаагүй зугтсан. Яагаад Сангийн яаман дээр энэ маргаан явж байх үед таны хамаарал

бүхий этгээдүүдийн холбоотой хамаарал бүхий ийм компани нэмж орж ирж 10 хувийг нь авч байдаг юм. Энэ хардах бүрэн үндэслэлтэй. 400 их наядын нүүрсний нөөцтэй ордын 10 хувь гэдэг бол 40 их наяд төгрөг, 10 тэрбум долларын асуудал энд яригдаж байгаа. Ямар үндэслэлээр энэ Сангийн яаманд ийм эрхүүд өгөөд байнгуут, энийг Сангийн сайд өөртөө давуу байдал болгож ашиглаж байна вэ гэдэг асуудалд хөндөгдөх ёстой. Битгий давраад бай.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүн үгээ хэлье.

Г.Дамдинням: Тэр яах вэ хүн, салбарууд ингээд зөв юм хийгээд байвал дэмжээд, хамгаалаад явах ёстой. Буруу юм хийгээд байвал бид нар дуугарч байх ёстой. Сүүлийн хэдэн өдөр би энэ ХААЯ-ыг нэлээн яриад байгаа. Сая жишээ нь гэхэд энэ Ургамал хамгааллын хуулийн тухай яригдаад байгаа юм агентлаг гээд. Ургамал хамгааллын агентлаг бол байж байх ёстой юм байна лээ. Монгол малын махыг эрүүл болгож, Монгол малыг гадаад улсуудад үнэтэйгээр экспортолж, малчин ард иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэхэд малын идэж байгаа өвс, тэжээл эрүүл байхыг баталдаг төрийн агентлаг, тэр нь олон улсын энэ эрүүл мэндийн ургамал, ургамлын эрүүл мэндийн байгууллагатайгаа холбогдож ажилладаг ийм бүтэц зайлшгүй шаардлагатай юм байна лээ. Тийм учраас энийг байгуулсан юм шүү. Тэгэхээр энийг дэмжих ёстой, байлгаж байх ёстой. Тэгээд энийг бол ад үзээд байх хэрэггүй.

Харин төмөр замтай, төмөр замын орцтой Улаанбаатар хот дотор шүү. Нефтийн агуулахтай, томоохон хэмжээний үл хөдлөх агуулах складуудтай, том хэмжээний газартай, хайгаад олдохгүй үнэ цэнтэй төрийн ийм өмчийг хэн нэг сайдын тааллаар зараад, аваачиж хэнд өгөх гэж байгааг нь мэдэхгүй шийдээд, тэгээд тэндээс орж ирж байгаа орлогоор юу ч хийх гээд байгаа юм тийм ээ, хэний барьсан, ямар барилгаас авч, хэнд хөрөнгө оруулалт хийх гээд байгаа нь мэдэгдэхгүй ажил хийгээд байвал харин зогсох ёстой байхгүй юу. Буруу. Төрийн өмчөөр ингэж тоглож болохгүй. Түүн дор бол харин энэ ашиггүй байгаа төрийн өмчийн компаниудаа зарж үрээд, татан буулгахыг нь буулгаад, зохион байгуулалтыг нь хийгээд ингээд явах ёстой байтал байгаа өмчөө үрэн таран хийнэ гэдэг асуудал бол байхгүй шүү. Энэ болохгүй шүү. Үнийг нь мэддэг хүн байхгүй. Яаж зарах гээд байгаа нь мэдэгдэхгүй, юу болоод байгаа нь мэдэгдэхгүй, сошиалаар нэг баахан хов жив. Ийм маягаар бид нар ажиллахгүй. Энэ дээр бол бид нар анхаарах ёстой шүү. Тийм учраас би энэ дээр дуугараад байгаа юм, хэлээд байгаа юм.

Энийг энэ хариуцаж байгаа хүмүүс нь анхаараарай. Гэртэйгээ ойрхон яамаа нүүлгээд явчихдаг сайдтай болчихоод байгаа шүү дээ хэдүүлээ. Бизнестэйгээ ойрхон салбараа аваад явчихдаг сайдтай болчихоод байгаа шүү. Нөгөө Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль яасан, нөгөө Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт яасан, авлига, албан тушаалын гэмт хэрэг яасан байхгүй. Зарчим шүү дээ энэ. Энэ зарчмын тухай дуугараад байгаа байхгүй юу. Түүнээс биш энд хувийн асуудал алга. Тэгээд хамтарлаа гээд ингээд хүчиндээд юм шийдээд байдаг байж болохгүй шүү дээ бид нар. Хэлэх ёстой юмаа Их Хурал хэлж байх ёстой. Гүйцэтгэх засаглал дээр явагдаж байгаа асуудлууд дээр байр сууриа илэрхийлж байх ёстой, чиглэлээ гаргаж байх ёстой. Энийгээ анхаараарай манай Засгийнхан.

Ц.Даваасүрэн: Мөнхтулга гишүүн үг хэлье.

П.Мөнхтулга: Нөгөө ААНОАТ-ын хууль дээр нэгэнт нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол тэр 22.5.1 дээр их бүдүүлэг заалт байдаг юм. Монгол Улсыг ерөөсөө 500, 1000 гэсэн километрээр хуваачихсан байдаг байхгүй юу. 499 дээрх, 499 км-ийн дээрх байгууллага яах юм бэ, тэнд байгаа байгууллага татварын хөнгөлөлт орохгүй. 1 км-ийн цаана байгаа яг 500 дээр байгаа байгууллага 50 хувь, 999 км дээр байгаа сумын байгууллага яах юм бэ, яг 1000 дахь километр дээр байгаа нь 90 хувь хөнгөлдөг байхгүй юу. Тэгээд энэ татварынхан манай Сангийн яамныхан илүү тоонд сайн хүмүүс баймаар юм. Монгол Улсаа шууд 500, 1000 гэсэн километрээр хуваагаад, түүнийгээ агаарын зайгаар тооцоод байгаа юм уу, авто замын километрээр тооцоод байгаа юм уу энэ болгоныгоо нарийвчлахгүй бол энэ зүгээр гадныхан харахад ч гэсэн, нэг тоо мэддэг оюутан харсан ч гэсэн их бүдүүлэг зохицуулалт байдаг юм. Тэгээд энийгээ боловсронгуй болгоод, энэ нэмэлт, өөрчлөлт дээрээ нэмээд оруулаад ирээч.

Энэ хуулиас чинь хойш бид нар чинь бүсчилсэн хөгжлийн загвар гээд юм хийгээд яваад байгаа шүү дээ. Энийгээ татварын хөнгөлөлтийн энэ бүр 22.5.1 чинь бол бүсчилсэн хөгжлийг хийх гэсэн анхны оролдлого юм шиг байгаа юм. Нэлээн дээр орсон өөрчлөлт. Энийг бас нэг боловсронгуй болгож оруулж ирээч.

Тэрэн дээр бас 5.1 дээр, юун дээр чинь 22.5 дугаар заалтад ер нь 22.8 дахь байгууллагууд чиглэлүүд орохгүй гээд байгаа юм. Тэгээд 22.8.5 дээр чинь ярианы үйлчилгээ буюу call center-ийг хэлээд байх шиг байна. Харин ч энэ call center чинь яахаараа заавал Улаанбаатарт бүгдээрээ бүгж байх ёстой юм. Хөдөө орон нутгууд руугаа гараад, хол байгаад, бүх дэлхийн call center Энэтхэгт цугларчихсан шүү дээ. Түүн шиг хөдөө орон нутагт ажлын байраа бий болгоод, энэ 22.8.5-ыг бараг хасаад хаячихмаар санагддаг юм.

Сая ингээд харахад институт хоорондын маргаан болоод байх шиг байгаа юм. Энэ дээр ганцхан юм яваад байгаа юм. Энэ бүх нэмэлт, өөрчлөлтүүд дээр. Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн гэсэн энэ малгайн доор л яваад байгаа юм. Тэгээд энэ Бүсчилсэн хөгжлийн бодлого гэдгийг Их Хурал нь баталж байгаа юм уу, ЗГ нь баталж байгаа юм уу, энийг баталж байгаа байгууллага, энийг гаргаж байгаа жагсаалт, энэ дээр байгаа жагсаалтад л энэ татвар ААН-үүдийн гаалийн болон хөнгөлөлтүүд ороод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ хэн нь батлах юм бэ гэхээр ЗГ нь өчигдрийн чуулган дээрээс асуухаар хаана яг боловсруулах үйлдвэр нь баригдах юм, хаана сургуулиуд нь нүүж очих юм, хаана энэ бүсчилсэн хөгжлийн энэ бүтээн байгуулалтууд чинь явах юм бэ гэхээр яг тодорхой хариулт байхгүй эцэслэгдээгүй байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн энэ татварын хөнгөлөлт, гаалийн хөнгөлөлтүүд гэдгийг энэ Бүсчилсэн хөгжлийн бодлого гэдгийг нь зүгээр Их Хуралд нь өгчих юм бол энэ бүх маргаан нь дуусчих юм биш үү гэсэн ийм санал байгаа юм. Тэгэхээр гол маргаан бол энэ Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн гэсэн энэ үг доор, энэ малгайн доор яваад байна шүү. Энийгээ Их Хурал нь батална гээд оруулчихад болчих юм шиг санагдаж байна. Тэгээд болсон.

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүн үг хэлье.

Д.Батбаяр: Төсөв алдагдалгүй байх ёстой гэдэг үндэслэлээр Ерөнхийлөгч хориг тавьсан. Улсын Их Хурлын гишүүд ч мөн санал нэгтэй хүлээж аваад, 2025

оны төслөөс эхлээд ахиад хэлэлцээд явж байна эхнээс нь. Дараа долоо хоногт Төсвийн зарлагын хяналтын хорооны хурал хуралдаж чадахгүйд хүрээд байна. Учир юу вэ гэхээр бүгдээрээ л ирэх оны төсөв яриад байдаг, цаг хугацаа нь ч мөн л дөө. Гэхдээ бид нар 2023, 2024 оны энэ төсвийн зарцуулалтаа бүгдийг нь мартаад байна. Төсвийн зарцуулалт дээр аудитын байгууллага шалгалт хийгээд, дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтээр төсвийн захиран зарцуулагчдын багагүй хувь дээр нь зөрчил илэрсэн. Зөрчил бүрд хариуцлага тооцох ёстой, алдаа гаргасан албан тушаалтан бүрд хариуцлага тооцох ёстой. Бүгдээрээ л мэдэж байгаа.

Аудитын дүгнэлтээр илэрсэн алдаа зөрчлүүдэд ямар хариуцлага тооцсон бэ гэдэг асуулт асуухад ерөөсөө хариу авч чадахгүй байгаад байгаа юм бичгээр. Аудитын дүгнэлт гарсан асуудал болгоныг шийдэж байж энэ төсвийн алдагдал, яриад байгаа энэ төсвийн алдагдал багасна, алдагдалгүй төсөв батлагдана, Монгол Улс хөгжинө. Энэ зөрчил алдааг хэрхэн залруулж байгаа талаар өнөөдөр ямар ч мэдээлэл байхгүй. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос албан бичгээр мэдээлэл шаардана, ямар ч хариу байхгүй байгаад байна. Ахиад би хэлчихье.

Тэгээд сая хориг тавигдсан төсвийг хэлэлцэж байхад энэ тухай асуудал шаардаж байсан байхгүй юу. Тэгэхэд тодорхой нэр бүхий хүмүүс орж ирээд 12 сард хариуг нь өгнө гээд л явсан. Ямар ч хариу байхгүй. Хурлын үеэр зүгээр 3, 4-хөн минут яриад өнгөрдөг, асуулт асуудаг, санал хэлдэг. Хороо нь, гишүүд нь тэгээд сонссон болоод л өнгөрдөг, хүмүүс нь, ажлын хэсгийнхэн нь тайлбар тавиад өнгөрдөг. Төсөв батлагдана, зарцуулалт дээр, бүртгэл дээр ямар ч хяналт байхгүй байгаад байна. Ингээд л нэг жил өнгөрнө, бүх юм мартагдаад л өнгөрдөг нь ингээд давтагддаг асуудал үүсээд байх шиг байна. Хариуцлага гэдэг зүйлийг хэн ч хүлээдэггүй, төрийн ажил ингэж явж болохгүй л дээ. Тэгэхээр аудитын дүгнэлтээр илэрсэн алдаа зөрчлүүдэд ямар хариуцлага тооцсон бэ гэдэг асуудлыг Зарлагын хяналтын дэд хороогоор авч хэлэлцэх ёстой. Энд хариулт өгөхгүй, эс үйлдлээрээ энэ хорооны үйл ажиллагааг тасалдуулахгүй байхыг би хүсмээр байгаад байгаа юм.

Улсын төсөв, орон нутгийн төсөв, эрүүл мэнд, боловсрол, хууль, эрх зүй гээд маш олон салбарынхан өнөөдөр ажлаа хийх гээд, санхүүжилтээ шийдүүлэх гээд хүлээгээд байж байгаа. Харамсалтай нь энэ зарлагын хяналтыг хийх боломж байхгүй байгаад байна. Тэгээд хаана хаанаа бүгдээрээ хариуцлагатай байцгаамаар байна гэдэг үгийг хэлье.

Ц.Даваасүрэн: Хаашаа бичиг өгсөн байсан юм бэ? Сангийн яам, аудит. Тэгвэл Сангийн яам, аудит энэ өмнө гарсан аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр ямар хариуцлага тооцсон бэ гэдэг мэдээллийг энэ амралтын өдрүүдэд багтаагаад нэг дэх өдөр гэхэд Зарлагын хяналтын дэд хороон дээр ирүүлсэн байхыг анхааруулъя. Г.Ганбаатар гишүүн үг хэлье.

Г.Ганбаатар: Энэ Ургамал хамгааллын тухай хууль гээд 10, энэ чинь хаашаа юм 20, бүүр 2007 онд батлагдаж байсан хууль юм шиг байна. Би бол нэг зүйлийг гайхаад байна л даа. Ингээд хууль гаргаад нэг агентлаг байгуулаад байгааг. Ургамал хамгааллын хүрээлэн тэгвэл юугаа хийх юм бэ? Хөдөө аж ахуйн их сургуулийн дэргэд чинь Ургамал хамгааллын хүрээлэн гээд их том хүрээлэн байгаа шүү дээ. Тэгэхэд дахиад хууль гараад, дахиад агентлаг байгуулаад иймэрхүү маягаар явсаар байтал чинь манай төрийн бүтэц чинь улам л том

болоод байгаа нь энэ шүү дээ. Энэ хүрээлэнгүүдтэй холбоотой нэг зүйлийг цаашид анхаармаар юм билээ. Би ингээд судалгааг нь татаад үзчихсэн. Монгол Улсад 35 хүрээлэн байгаа байхгүй юу. Боловсролын яамны хажууд гэхэд 28 хүрээлэн. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамны хажууд гээд ингээд, энэ олон 35 хүрээлэн. Тэгээд энэ олон хүрээлэн байхад чинь хажууд нь дахиад тусдаа агентлаг байгуулахын хэрэг байгаа юм уу?

Цаашдаа ер нь ингээд хууль гаргаад, агентлаг шинээр байгуулаад байдаг. Зөвхөн 2016 онд гэхэд энэ хүрээлэн байна уу, энэ төсөвт байгууллагууд байна уу бид нэг 1 их наядын л төсвийн, үгүй ээ цалингийн фондтой байсан юм байна лээ шүү дээ. Одоо 6 их наяд хүрчхээд байна шүү дээ. Тэгэхээр цаашдаа энийгээ бид анхаарахгүй юм уу? Энэ тал руу өөрөөр хэлбэл бид чинь өөрсдөө хууль санаачлах юм, хууль гаргаад л зардлаа нэмээд байдаг, хууль гаргаад л түүнтэй уялдаад л улам зардал өсөөд байна шүү дээ. Энэ тал дээр бас Төсвийн байнгын хорооныхон цаашдаа бодолцох хэрэгтэй байх.

Ц.Даваасүрэн: Тийм, ер нь Ганбаатар гишүүний хэлж байгаа үнэн шүү. Бид нар ингээд шууд механикаар хасах шийдвэр гаргаж байгаа байхгүй юу зардлыг. Тэр чинь төсвөө сайн зарцуулж байгаа төсвийн эрх захирагч хохирч байгаа байхгүй юу. Харин нөгөө үрэлгэн байсан, орон тоогоо нэмчихсэн улсууд нь монжоод өнгөрөх гэж байгаа байхгүй юу. Тийм учраас ер нь ингээд хасалт таналтыг хийхийн тулд 1 дүгээрт хийх арга хэмжээ бол бүтцийн өөрчлөлт. Энэ олон яамнууд бий болсон, яамдаа дагаад олон салбарын агентлагууд бий болсон. Энэний чинь цаана хамгийн том зардал явж байгаа. 2000 онд цалингийн сан 2 их наяд гаруйхан л байсан. Одоо 7,8 их наяд шүү дээ, 3 гаруй дахин өсчихсөн байгаа шүү дээ. Энэ чинь л төсөв тэлээд байна шүү дээ. Тийм учраас энэ бүтцийн өөрчлөлтийн асуудал гэдэг дээр ер нь цаашид анхаарал хандуулахгүй бол болохгүй нь гэж.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Санал хураалтыг дагаж байгаа хууль нэг бүрээр хураалгах юм байна шүү гишүүдээ анхааралтай байгаарай. Санал хураалт явуулъя.

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 69,6 хувиар уг санал дэмжигдсэн байна. Аубакир гишүүнийг дэмжсэнээр авлаа.

2 дахь санал. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 17 гишүүн дэмжиж, 73,9 хувиар уг санал дэмжигдсэн байна. Батлут гишүүнийг дэмжсэнээр авъя.

3 дахь санал. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь, хэлэлцэх нь зүйтэй гэсэн, дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, 69,6 хувиар уг санал дэмжигдлээ. Батлут гишүүнийг дэмжсэнээр авлаа.

4 дэх санал. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, 69,6 хувиар дэмжигдлээ. Мэндсайхан гишүүн дэмжсэн байна.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн, хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 17 гишүүн дэмжиж, 73,9 хувиар энэ санал дэмжигдлээ.

6.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл ангийн, зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 14 гишүүн дэмжиж, 60,9 хувиар уг санал дэмжигдлээ. 7, Батлут гишүүнийг дэмжсэнээр авах юм байна. Зөрчлийн тухай, Мөнхсоёл гишүүн бас.

Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 17 гишүүн дэмжиж, 73,9 хувиар дэмжигдлээ. Батлут гишүүн бид 2-ыг дэмжсэнээр авъя.

9, 8 уу? 8.Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 14 гишүүн дэмжиж, 60,9 хувиар дэмжигдлээ. Батжаргал гишүүн, Батлут гишүүн, миний бие ингээд энэ 3 хүнийг дэмжсэнээр авъя.

Олон санал хураалгаад ирэхээр үү. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжиж, 78,3 хувиар дэмжигдлээ. Батлут гишүүнийг дэмжсэнээр авлаа.

10.Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжиж, 73,9- хувиар уг санал дэмжигдлээ.

11.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж, 78,3 хувиар уг санал дэмжигдлээ.

13, 12 сая явчихсан тийм ээ. 12.Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 19 гишүүн дэмжиж, 82,6 хувиар уг санал дэмжигдлээ.

13 дахь санал хураалт. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 23 гишүүн санал хураалтад оролцож, 19 гишүүн дэмжиж, 82,6 хувиар уг санал дэмжигдлээ. Батлут гишүүнийг дэмжсэнээр авлаа.

14 дэх санал хураалт. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж, 78,3 хувиар уг санал дэмжигдлээ.

Сүүлийн санал хураалт. 15.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж, 78,3 хувиар уг санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Дээрх 11 хууль, 4 тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн дээрх хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

11.21 цаг

Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Баярлалаа гишүүддээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

